Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн сэтгүүл 2013. 02 сар. №03 (037) www.mongolianeconomy.mn

Бидэнд бусдад таалагдах юу байна вэ

Хойд туйл урсаж байна

БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ БАЯЛАГ БОЛГОХ НЬ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

УУЛ УУРХАЙН ЯАМ



МЭНДЧИЛГЭЭ

Эрхэмсэг зочид, төлөөлөгчид, хатагтай, ноёдоо

"Coal Mongolia-2013" олон улсын чуулга уулзалтанд уригдан оролцож байгаа дотоод, гадаадын зочид, төлөөлөгчид, зохион байгуулагчид та бүхэнд ажлын амжилт сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж мэндчилж байна.

Монгол Улсад уул уурхайн салбар үүсч хөгжөөд 90 жилийнхээ босгыг давлаа. Энэ хугацаанд Монгол Улс болон уул уурхайн салбар олон бэрхшээл саадыг давж Монгол Улс өнөөгийн ардчилсан нийгмийг цогцлооход үнэтэй хувь нэмэр оруулж, дэлхийн уул уурхайн салбарын нэгэн чухал хэсэг боллоо. 2012 оны жилийн эцсийн байдлаар уул уурхайн салбар ДНБ-ий 18,6 хувь, Аж үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүний 67 хувь, экспортын нийт бүтээгдэхүүний 87,7 хувийг эзэлж байгаа

Нүүрсний салбар нь Монгол орны геологи уул уурхайн үйлдвэрийн анхдагч гэдгээрээ ялгардаг. Монгол Улсын нүүрсний нөөц 173,3 тэрбум тонн орчим бөгөөд энэ хэмжээгээр дэлхийд дээгүүрт орж байна. Энэ нь олон улсын зах зээлд Монгол Улсын нүүрсний салбарын өрсөлдөх чадвартай салбарын тоонд зүй ёсоор оруулж байна. 2012 онд Монгол Улс 31,1 сая тн нүүрс олборлож үүнээс 20,5 сая тн нүүрсийг экспортолж улсын төсөвт 828.5 тэрбум төгрөгийн орлого оруулсан юм. Энэ нь чамлашгүй амжилт бөгөөд манай нүүрсний салбарт ажиллаж байгаа уурхайчид, компануудын хүчин зүтгэл, нөр их хөдөлмөрийн үр дүн юм.

Уул уурхайн яам Монгол Улсын нүүрсний салбарыг хөгжүүлэн бадраах богино, дунд, урт хугацаанд баримтлах бодлогыг боловсруулан ажиллаж байна.

Нэгэнт нүүрсний салбар нь олон улсын зах зээлд манай улсын өрсөлдөх чадвартай салбар учраас энэ салбарын хөгжлөөс Монгол Улсын хөгжил ихээхэн хамааралтай гэдэг нь ойлгомжтой юм. Иймээс манай нүүрсний салбарынхан нүүрсийг нэмүү өртөг шингээж боловсруулан дэлхийн зах зээлд ойрхон үнээр борлуулан экспортлох, нүүрсний орчин үеийн цахилгаан станцуудыг нүүрсээр хангах, улмаар цахилгаан эрчим хүч экспортлогч орон болох, хагас кокс түлш үйлдвэрлэх, нүүрс-химийн аж үйлдвэрийг хөгжүүлэх, нүүрсний метан хийг ашиглах, энэ салбарт тэргүүний технологи, менежментийг нэвтрүүлэх зэрэг томоохон зорилтуудыг өмнөө тавин ажиллаж байна.

Ашигт малтмал, түүнчлэн нүүрсний салбарт ил тод, хариуцлагатай, аюулгүй, хүний эрүүл мэндэд халгүй, байгаль орчинд ээлтэй, харилцан ашигтай, хууль дээдэлсэн үйл ажиллагаа, эдгээр зарчмыг баримталж ажиллах болно. Хөрөнгө оруулагч Та бүхэнд Монгол улсын шинэчлэлийн Засгийн газар, Уул уурхайн яам ямагт нээлттэй байх болно.

"Coal Mongolia-2013" чуулга уулзалтанд оролцогч та бүхэн Монгол Улсын нүүрсний салбарыг хөгжүүлэхэд шинэлэг, оновчтой, олон санаа, бодлого гаргана гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэнд амжилт хүсье.
Сайн үйлс дэлгэрэх болтугай.

УИХ-ын гишүүн,
Засгийн газрын гишүүн
Уул уурхайн сайд

Д.Ганхуяг

НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 3 ДАХЬ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН

COAL MONGOLIA 2013

2013 оны 2 сарын 21-22

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, SS CONVENTION CENTER

Зохион байгуулагч

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР УУЛ УУРХАЙН ЯАМ

MINING.MN

"Платинум" ивээн тэтгэгч

MONGOLIAN MINING CORPORATION

HERA Equipment LLC — OFFICIAL DISTRIBUTOR OF Wirtgen

"Даймонд" ивээн тэтгэгч

HUNNU COAL

Албан ёсны дэмжигч байгуулагууд

МИНЕРАЛ МАЛТМАЛЫН ГАЗАР MINERAL RESOURCES AUTHORITY

МУУҮА МИМА

THE BUSINESS COUNCIL OF MONGOLIA

Mongolian Mining Club

ZAZA CORPORATE COUNSEL LLC

NAMBC

MAMCE

"Гоулд" ивээн тэтгэгч

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ERDENES-TT

XacBank Right Bank

БАГАНУУР ХК

MoEnCo MONGOLIA ENERGY CORPORATION МОНГОЛИА ЭНЕРЖИ КОРПОРАЦИ

GEMCOM becomes GEOVIA

ASPIRE MINING LTD

TERRA ENERGY

ШИВЭЭ ОВОО ХК

GLOGEX Geology & Mining Consulting Services

Ивээн тэтгэгч банк

TDB TRADE & DEVELOPMENT BANK

Чуулганы үйл ажиллагааг ивээн тэтгэгчид

KHAN BANK

Deloitte.

GOLOMT BANK Committed to and Investing in Excellence

MINES UP

carhartt Exclusive distributor

WAGNER ASIA EQUIPMENT LLC CAT

TRANSWEST MONGOLIA LLC

MobiNet leading internet technology

KPM telematics

МОНАА

Олон улсын хэвлэл мэдээллийн хамтрагчид

Bloomberg TV MONGOLIA

InfoMine Mining Intelligence & Technology

China Coal Resource

ASIA Miner

РАЦИОНАЛЬНОЕ ОСВОЕНИЕ НЕДР

BAIINFO

COAL INTERNATIONAL

ChinaMineral 中国矿权交易网

COAL SPOT.COM

WORLD COAL

Mining Journal

MINING LEADERS

globalCOAL

ASIA TODAY

Mining, People & Environment Driving change and awareness

OXFORD BUSINESS GROUP

Дотоодын хэвлэл мэдээллийн хамтрагчид

MONGOLIAN ECONOMY

MONTSAME

MINING & MONEY УУЛ УУРХАЙ БА МӨНГӨ СЭТГҮҮЛ

Mining Journal

Баялаг

iRMUUN

Өглөөний сонин

UB 코리아 타임즈 KOREA TIMES

Дэлгэрэнгүй мэдээллийг:
Утас: +976-70115590, Факс: +976-70125590
Э-шуудан: info@coalmongolia.mn, registration@coalmongolia.mn
www.coalmongolia.mn

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800-6228/

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:
Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

СЭТГҮҮЛЧИД:
Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Б.Уганбаяр
Х.Хулан
Б.Үүрийнтуяа

ОРЧУУЛАГЧ: Б.Заяа

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР: Ш.Оюундарь
ПРОГРАММИСТ: Б.Лхагвачулуун

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР: Д.Барианжав /8880-0825/
Д.Баттулга /9902-2279/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР: С.Цэнд-Аюуш /8870-3633/

“ECONOMY” ТВ СТУДИ

ЗУРАГЛААЧ: Ц.Бат-Отгон
ГРАФИК ДИЗАЙН Г.Буянбаатар

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:
"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall" салбарууд

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

MONGOLIAN ECONOMY
ОНЛАЙН ЗАХИАЛГА

www.mongolianeconomy.mn

Төвөөс зугтах хүч Оюутолгойд үгүй



Шатрын өрөг дээр буй Оюутолгой төслийн нүүдлийг Монголын Засгийн газар болон “Рио Тинто” тэргүүтэй хөрөнгө оруулагч хамтдаа шийдэх учиртай. Түүнээс толгой мэдэн нүүх эрх хэн, хэнд нь байхгүй... 8

Ирэх жилийн чуулганаар Монголын тухай хэлэлцэнэ



Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж тэргүүтэй албаныхан өнгөрсөн сарын 23-27-нд Давосын дэлхийн эдийн засгийн чуулганд амжилттай оролцоод ирсэн билээ...16

Төрхөмдөө буцах төсөв



...Төсвийн зарлагыг төлөвлөхдөө зардлын шинэ бөгөөд томоохон хоёр хүчин зүйлийг оруулж тооцоогүй байна...22

“Би бусдаас илүү ажиллах ёстой”



“Mongolian Economy” сэтгүүл “Захирлууд” гэсэн шинэ булан нээлээ. Энэхүү буланд бизнес нь амжилттай яваа компаниудын захирлуудыг урьж оролцуулж, удирдах арга барил, бизнесийн туршлагаас нь хуваалцах зорилготой юм. Анхны зочноор BSB компанийн захирал Б.Жаргалсайханыг урилаа...37

УУЛУУРХАЙ

8 Төвөөс зугтах хүч Оюутолгойд үгүй

10 “Гамшгийн” хууль

12 Төсвийн эрүүл бодлого ба баялгийн сангийн үүрэг

ЭДИЙН ЗАСАГ

16 Ирэх жилийн чуулганаар Монголын тухай хэлэлцэнэ

18 Голланд өвчнөөс голланд гайхамшиг руу

19 Бидэнд бусдад таалагдах юу байна вэ

22 Төрхөмдөө буцах төсөв

24 Орон сууцны үнэ өсөх төлөвтэй байна

27 Ойрын хугацаанд санхүүгийн хямрал болох уу

30 Үндэстэн дамнасан корпорациудын өсөн нэмэгдэж буй байр суурь

ЕРТӨНЦ

32 Хойд туйл урсаж байна

БИЗНЕС

35 “Би бусдаас илүү ажиллах ёстой

40 Шинэ технологи шинэ боломж

МОНГОЛД

Уул уурхай



Төрийн өмчит "Эрдэнэс Тавантолгой" хувьцаат компани нийтдээ 500 гаруй сая ам.долларын алдагдалд орж ажиллагаа нь зогсонги байдалд ороод байгаа. Өнгөрсөн онд нүүрсний дэлхийн зах зээлийн үнэ 30 орчим хувиар буурсан болон эргэлтийн хөрөнгийн зориулалттай зээлийн эх үүсвэрийн 60 гаруй хувийг "Хүний хөгжил сан"-д төвлөрүүлсэн, БНХАУ-ын "Чалко" компанитай байгуулсан гэрээ зэрэг гадаад болон дотоод хүчин зүйлээс хамаарч тус компанид дээрх хэмжээний эрсдэл учирсан аж. Тиймээс "Эрдэнэс Тавантолгой" компанийн өрийг барагдуулахад шаардлагатай хөрөнгийг Чингис бондоос гаргахаар УИХ-аар хэлэлцэж байна.

Уул уурхайн яамнаас "Шатдаг занар" хөтөлбөр боловсруулж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад шатдаг занарын эрэл хайгуул хийх, олборлох, боловсруулах, ашиглах бололцоог судалж эхэлжээ. Мөн нийлэг газрын тос, хийн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгохоор төлөвлөсөн байна. Манайх АНУ-ын "Жени ойл энд газ" компанитай "Шатдаг занараас хийн конденсат гаргах боломжийг тодорхойлох судалгааны ажлын гэрээ" байгуулжээ. Мөн Франц улсын "Тотал" компани Монгол Улсад шатдаг занарын хайгуул, судалгаа хийх санал ирүүлсэн байна.

Дэд бүтэц

БНХАУ-ын Засгийн газраас Монголын Засгийн газарт олгох хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Улаанбаатар хотод зургаан гүүрэн гарц, олон түвшний огтлолцолтой зам барих төсөл хэрэгжүүлэхээр болсон. Төслийн гүйцэтгэгчээр урд хөршийн компаниуд ажиллах аж. Төслийн ажил энэ сарын 15-наас эхэлж, 2015 онд дуусна.

Банк, санхүү

УИХ-аас Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль баталсантай холбоотой Хадгаламжийн даатгалын корпораци байгуулахаар боллоо. Үүнийг Сангийн яам, Монголбанкны хамтарсан ажлын хэсэг хариуцаж байна. Ажлын хэсэг одоогоор Хадгаламжийн даатгалын сангийн эх үүсвэр бүрдүүлэх, банкуудыг хадгаламжийн даатгалд хамруулах, тус байгууллагын хүний нөөцийг бүрдүүлж, сургаж эхлээд байна.

Монголбанкнаас гаргасан судалгаагаар манай улсын нийт хадгаламж 2011 оныхоос нэг их наяд төгрөгөөр өсч, 4.9 их наяд төгрөгт хүрсэн байна. Тухайлбал, аж ахуйн нэгж байгууллагын төгрөгийн хадгаламж 378.8 тэрбум төгрөг болсон бол иргэдийн төгрөгийн хадгаламж 3.1 их наяд төгрөг болжээ. Түүнчлэн гадаад валютын хадгаламж өнгөрсөн оныхоос 46.7 хувиар өсч, 1.4 их наяд төгрөгт хүрсэн байна.

Эдийн засаг

Засгийн газар улсын төсөв боловсруулахдаа эдийн засгийн өсөлт, дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ зэрэг гадаад дотоод олон хүчин зүйлд тулгуурладаг. Тухайлбал, энэ оны төсөвт зээсийн үнийг тонн тутамд 6330 ам.доллар, боловсруулсан коксжих нүүрсний үнийг 131.5 ам.доллар байхаар тооцсон байна. Хэрвээ тооцоолсон үнээс илүү гарвал тухайн мөнгийг Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулахаар зааажээ.

Жилийн дундаж үнэ (ам.доллар/тонн)

	2012	2012	2014
Зэс	7970	7965	7775
Алт	1679	1749	1655
Цайр	1956	2040	2125
Коксжих нүүрс	211	203	213
Эрчим хүч нүүрс	98	105	111
Төмрийн хүдэр	125	120	122
Газрын тос/Нимскс	92	85	83

Эх сурвалж: ННФ

ДНБ-ий өсөлтийн прогноз дэлхийн зарим орноор /хувиар/

Үзүүлэлт	2012	2012	2014	2015	2016	2017
Дэлхийн эдийн засаг	2.5	2.6	3.1	3.6	3.8	3.7
Хөгжингүй орнууд	1.2	0.9	1.5	2.2	2.5	2.2
АНУ	2.2	1.6	3.0	3.5	4.0	3.0
Япон	1.6	0.7	0.7	1.5	1.2	1.2
БНСУ	2.3	3.4	4.0	4.1	4.2	3.8
Евро бүс	-0.4	-0.7	-0.4	0.7	1.1	1.3
Хөгжиж буй орнууд	4.7	5.3	5.5	5.5	5.6	5.7
БНХАУ	7.7	7.8	7.3	7.0	7.5	7.3
Энэтхэг	5.4	6.2	6.9	7.3	7.4	7.5
Монгол Улс	12.0	13.8	11.0	-	-	-

Эх сурвалж: ННФ

"Сити" банк дэлхийн эдийн засгийн байдал, голлох орнуудын эдийн засгийн өсөлтийг Олон улсын валютын сангийн тооцоонд суурилан шинэчлэн гаргасан байна.

ДЭЛХИЙН ДАХИНД



Өнгөрсөн онд Хятад улс дэлхийн зах зээлд 403.05 тонн алт нийлүүлж, зургаа дахь жилдээ дэлхийн хамгийн том алтны нийлүүлэгч болсон тухай Синьхуа агентлаг мэдээллээ. Тус улсын Алтны үндэсний холбооноос гаргасан судалгаанд Хятадын алтны үйдвэрлэл сүүлийн хагас зуунд 100 дахин нэмэгдсэн хэмээн онцолжээ. Мөн тус холбоо Хятадын алтны хэрэглээ өнгөрсөн арванхоёрдугаар сард 761.05 тоннд хүрсэн хэмээжээ. Ийнхүү урд хөрш Энэтхэгийн араас дэлхийн хоёр дахь том алтны хэрэглэгч болж буй юм.

АНУ-ын автомашин худалдааны томоохон компани болох “General Motors”-ын Хятад дахь борлуулалт өнгөрсөн сард жилийн өмнөх үетэй харьцуулахад 26 хувиар буюу 310.765 машинаар өсчээ. Энэ нь тус компанийн Хятад дахь борлуулалт хамгийн сайн байсан сар юм. Өмнө нь 2011 оны нэгдүгээр сард 268.035 машин борлуулсан амжилт гаргаж байжээ.

Хятадын Засгийн газраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өсгөх болсноо мэдэгдлээ. Үүгээрээ улам бүр ялгарч буй баян ядуугийн ялгааг сааруулахыг зорьж байна. Энэхүү шинэ төлөвлөгөөний хүрээнд цалингийн доод хэмжээг 2015 он гэхэд 40 хүртэлх хувиар нэмэх аж. Төрийн өмчийн компаниуд орлогынхоо дийлэнх хувийг төрийн санд төвлөрүүлдэг болох юм. Засгийн газраас 2015 он гэхэд 80 гаруй сая хүнийг ядуурлаас гаргахаар төлөвлөж байна.

Европын сэргээн босголт хөгжлийн банк өнгөрсөн 20 жилийн хугацаанд Оросын эдийн засагт 20 гаруй тэрбум еврогийн хөрөнгө оруулалт хийжээ. Үүнд өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлээс эхлээд томоохон бүтээн байгуулалт зэрэг бараг бүх хүрээг хамарсан нийт 750 төсөл хэрэгжих аж. Өнгөрсөн онд л гэхэд 2.5 тэрбум еврогийн хөрөнгө оруулалтыг 70 гаруй төслөөр дамжуулан хийсэн байна.



ОХУ-ын өнгөрсөн сарын инфляци 6.6 байсан бол энэ сард 7.1 хувь болж өссөн тухай Москва дахь Холбооны статистикийн үйлчилгээний газраас мэдээллээ. Өргөн хэрэглээний барааны үнэ өнгөрсөн сард эдийн засагчдын таамаглаж байснаас өндөр буюу нэг хувьд хүрсэн нь сүүлийн 15 сард гарч буй хамгийн өндөр үзүүлэлт юм.

ОХУ-аас Швецарь руу экспортлох тугалгын хэмжээ өнгөрсөн онд 1990 оноос хойш хамгийн бага үзүүлэлттэй гарчээ. Тээвэрлэлт 72 хувиар буурч, бүтээгдэхүүн нийлүүлэлт 154.600 унцид хүрсэн байна. Өнгөрсөн арванхоёрдугаар сард Швецарь Оросоос 6.462 унци тугалга импортолсон тухай Лондоны “Barclays” олон улсын банк, санхүүгийн үйлчилгээний компаниас мэдээлжээ. ■

А.АМАРСАЙХАНЫ БУЛАН





ТӨВӨӨС ЗУГТАХ ХҮЧ ОЮУТОЛГОЙД ҮГҮЙ

Б.БАЯРТОГТОХ

...Шатрын өрөг дээр буй Оюутолгой төслийн нүүдлийг Монголын Засгийн газар болон “Рио Тинто” тэргүүтэй хөрөнгө оруулагч хамтдаа шийдэх учиртай. Түүнээс толгой мэдэн нүүх эрх хэн, хэнд нь байхгүй...

1

Манай улсад Тогтвортой байдлын дөрөв, Хөрөнгө оруулалтын нэг, Бүтээгдэхүүн хуваах 15 гэрээ үйлчилж байна. Хөрөнгө оруулалтын нэг гэрээ нь Оюутолгой төсөл. Оюутолгой төслийн хувь нийлүүлэгчдийн VI хуралдаан энэ сарын 6-нд болж, хөрөнгө оруулагч талууд “Их тэнгэр” цогцолборт хэлэлцээрийн ширээний ард суулаа. “Оюутолгой” компани оны өмнөхөн баяжуулах үйлдвэрээ нээсэн. Удтал хүлээсэн төслийн бүтээн байгуулалт эрчимжиж, анхны зэсийн баяжмалаа Цагаан сарын өмнөхөн үйлдвэрлэж, “Ханбумбат” хэмээх нисэх онгоцны буудлыг ашиглалтад оруулаа. Энэхүү бүтээн байгуулалтын үйл явдалтай зэрэгцэн Оюутолгой төслийн асуудлаар Монгол төрийн гурван өндөрлөг өөрсдийн байр сууриа илэрхийлсэн нь хөрөнгө оруулагчдад гэнэтийн “шок” болов. Товчхондоо, Монголын төр Оюутолгой төслийн хөрөнгө оруулагчдад сануулга өгч, Хөрөнгө оруулалтын гэрээг эргэн сануулаа. Өөрөөр хэлбэл, Монголын төр Оюутолгойн асуудлаар цэгц ойлголттой болж, өөрсдийн байр сууриа бататгаж авав. Өмнө нь хөрөнгө оруулалтын гэрээний асуудлаар УИХ-ын нэр бүхий хэдхэн гишүүн “ярьдаг”. Тэд л Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээг тойрсон “болохгүй” асуудлыг хөнддөг байв. Харин намрын чуулган хөрөнгө оруулалтын гэрээг баталсан цагаас хойших ээдрээтэй асуудлыг “сэргээж”, хоёр тал хэлэлцээрийн ширээнд суух үйл явдлыг түргэсгэв.

2

Монголын Засгийн газар, “Рио Тинто” компанийн хооронд үүссэн үл ойлголцол, хөрөнгө оруулалтын гэрээг тойрсон маргааныг Хувь нийлүүлэгчдийн хуралдаан цэглэх учиртай. Түүнчлэн Засгийн газар дөрвөн сайдаа хэлэлцээрт оруулж, үр дүнг хүлээж сууна. “Рио Тинто” компани ч мөн адил үүнийг хүсэж буй. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ том ажлын эхлэлийг тавьсан нь үнэн. Гэхдээ дутуу дулимаг, алдаа мадагтай зүйлийг нь сайжруулах ёстой. Засгийн газрын зүгээс Хувь нийлүүлэгчдийн энэ удаагийн хурлаар хөрөнгө оруулалтын бодит баримтыг тодорхой болгох, үнэлгээг бодитой тооцох, хот суурин байгуулах зэрэг асуудлыг ярих ёстой” гэв. Хэлэлцээрт Монголын багийг Уул уурхайн сайд Д.Ганхуяг ахалж, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюун, Сангийн сайд Ч.Улаан нар оролцож байна. Мөн Монголын талаас хэлэлцээрт зургаан асуудлыг хөндсөн. Үүнд, Монголын талд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн компанийн сонирхлын зөрчил, Хөрөнгө оруулалтын гэрээний хууль, тогтоомжтой нийцэхгүй байгаа заалт, Төслийн хөрөнгө оруулалтын зардал өссөн болон техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийн хэрэгжилт, “Антре гоулд”-ын эзэмшилд буй тусгай зөвшөөрөл, Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилт, Менежментийн үйлчилгээний төлбөр гэсэн асуудал багтаж буй.

Монголын төр “Оюутолгой” компани болон хөрөнгө оруулагчаас зөвхөн хууль дээдлэхийг шаардахын зэрэгцээ үүсээд буй нөхцөлд байдалд бодитой хандахыг хүсэж байгаагаа илэрхийлсэн. Харин “Рио Тинто” компани Монголын Засгийн газарт зээлсэн 250 сая ам.долларыг өнгөрсөн оны татварын орлогоос суутгаж тооцох учиртай гэсэн хариу барив. Өөрөөр хэлбэл, “Рио Тинто” компани Монгол Улсыг 250 сая ам.долларын өрөө төлөхийг шаардлаа. Мэх мэхэндээ гэдэг шиг хоёр тал бие биеийнхээ сул талаар эхний хэлэлцүүлгээ эхэлсэн ч үр дүнг өгүүлэхэд эрт байна. “Оюутолгой” компани 2012 онд татвар төлөөгүй хэмээн Сангийн сайд Ч.Улаан өгүүлсэн. Тиймээс Засгийн газрын зүгээс Монгол Улсын хууль тогтоомжийг чандлан мөрдөх асуудлыг хөрөнгө оруулагч талд тавьжээ. Харин Оюутолгой компанийн зүгээс Монголын Засгийн газарт 803 сая ам.долларын татвар, төлбөр, хураамж, урьдчилгаа байдлаар төлсөн хэмээн дээрх мэдээллийг үгүйсгэв.

3

Оюутолгой төсөл хэзээд олон нийтийн анхаарлын төвд байж ирсэн. Тиймээс төвөөс зугтах хүч Оюутолгойд үгүй. Хэдий баялгийн эзэд хатуу үг унагасан ч Хөрөнгө оруулалтын гэрээнээс гажих учиргүй. Гэтэл хөрөнгө оруулагч тал тоглоомын дүрмээ зөрчиж байгаад Монголын тал тэвчээр алджээ. Үүнийг дээр өгүүлсэн УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгчийн байр суурь нотолж байна. Учир нь Оюутолгой төслийн анхны хөрөнгө оруулалт хоёр тэрбум орчим ам.доллар буюу 40 гаруй хувиар нэмэгдсэн.

Монголын Засгийн газартай хийсэн Хөрөнгө оруулалтын гэрээнд

Оюутолгойн анхны хөрөнгө оруулалтын хэмжээг 5.1 гэж заасан ч өдгөө 7.1 тэрбум ам.доллар болж өссөн. Хөрөнгө оруулалтын зардал хоёр тэрбум ам.долларааp өссөн нь эргэлзээ төрүүлэх үндэслэл болжээ. Үүний шалтгааныг олохоор Монголын тал хэдэнтээ албан бичиг илгээсэн ч хөрөнгө оруулагчийн зүгээс тодорхой хариулт өгөхгүй өнөөдрийг хүрчээ. Хөрөнгө оруулалтын зардал 40 орчим хувиар өссөн шалтгааныг “Рио Тинто” компанийн алдагдалтай холбоотой хэмээн УИХ-ын зарим гишүүд тайлбарлаж байна.

2011 онд төслийн хөрөнгө оруулалтад Монголын талаас хөндлөнгийн үнэлгээ хийлгэхэд нэг тэрбум 50 сая ам.долларааp хэтрүүлсэн гэсэн Үндэсний аудитын газрын дүгнэлт гарсан аж. Тиймээс Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын зардалд аудитын шалгалт хийх ёстой хэмээн УИХ-ын гишүүд үзэж байгаа юм. Мөн санхүүгийн шалгалтад “Оюутолгой” компанийг оруулах шаардлагатай гэж дүгнэсэн.

Төслийн зардал өсөх нь аль ч талд ашигтай бус. Өөрөөр хэлбэл, зардал тэлэхийн хэрээр ашиг буурна. Түүнчлэн монголчуудын ногдол ашиг хүртэх хугацаа хойшилж, төслийн өгөөж саарах эрсдэлийг дагуулж буй. Оюутолгой төсөл цаашид ч хөрөнгө ихээр шаардах болoлтой. Төслийн нэмэлт хөрөнгө оруулалт 14.6 тэрбум ам.долларт хүрэхээр байгаа аж. Энэ тохиолдолд 2019 онд ногдол ашиг авах боломжтой. Харин төслийн нэмэлт хөрөнгө оруулалт 24.4 тэрбум ам.долларт хүрвэл ногдол ашиг хуваах хугацаа 2033 он болж хойшлох талтай. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын зардал төлөвлөж байснаас 9.8 тэрбум ам.долларааp илүү гарна гэсэн үг. Түүнчлэн Оюутолгой төслийн зардал дэлхийн жишгээс 2.5 дахин өндөр байгааг энд тэмдэглэхэд илүүдэхгүй болов уу.

“Оюутолгойн арилжааны үйлдвэрлэл явуулах үе менежментийн төлбөрийн хэмжээ жилийн 60-80 сая ам.доллар байх төлөвтэй байна” гэж “Оюутолгой компани” мэдэгдсэн. Мөн зардал өссөнөөр менежментийн үйлчилгээний төлбөр бас нэмэгдэх боловч зардлыг өсгөх сонирхол “Рио Тинто” компанид байхгүй гэдгээ хэлэлцээрийн өмнө илэрхийлсэн юм. Төслийн санхүүжилт өсөх, ногдол ашгийн алдагдал хүлээх нь “Рио Тинто”-гийн хувьд менежментийн үйлчилгээний төлбөр авахаас илүү хор уршигтай гэж тэд үзжээ. Одоогийн байдлаар хөрөнгө оруулагчид Оюутолгой төслийн дараагийн үе шатны бүтээн байгуулалтыг явуулах зорилгоор олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас төслийн санхүүжилт босгохоор ажиллаж байгаа аж.

4

Өнөөдрийн байдлаар Оюутолгой төслийн 34 хувийг эзэмшиж буй Монгол Улс 705 сая ам.долларыг хүүгийн хамт хөрөнгө оруулагч талд төлөхөөр байна. “Бид гэрээний хэрэгжилтийг хянана, гүйцэтгэлийг хангуулна. Хөгжил, дэвшил, бүтээн байгуулалтыг говьдоо үлдээмээр байна. Оюутолгой хууль хэрэгжүүлдэг, ил тод, хариуцлагатай ажилладаг соёлыг Монголд үлдээх ёстой” хэмээн Ерөнхийлөгч мэдэгдсэн.

Монгол Улсын Засгийн газар Оюутолгойн халаасанд багтсан уу, Оюутолгой төсөл улс төрийн халаасанд өртсөн үү. УИХ-аас Засгийн газарт өгсөн чиглэлийн дагуу Оюутолгой ордын Хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах хэлэлцээрийг хийснээр тус компаниас энэ оноос эхлэн ашигт малтмалын нэмэлт нөөц ашигласны төлбөрийг авах, мөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зарим хөнгөлөлт, чөлөөлөлтийг бууруулах замаар төсвийн орлогыг 445.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр 2013 оны төсөвт тусгасан. Хэрэв хувь нийлүүлэгчдийн хуралдаан амжилтгүй болох аваас улсын төсвийн орлого дээрх хэмжээгээр сох дутна гэсэн үг. Гэсэн ч энэхүү өөрчлөлтийг хөрөнгө оруулагч зөвшөөрөх эсэх нь тун бүрхэг байна. Өмнө нь дээрх асуудлаар нэг бус удаа хоёр тал ярилцсан ч үр дүнд хүрээгүй билээ.

5

Газрын хэвлийд буй баялаг нь монголчуудынх боловч хөрөнгө оруулагч тал удирдлагын багт давуу эрхтэй оролцож ирсэн нь үнэн. Тухайлбал, УИХ-ын гишүүн С.Ганбаатар, Б.Бат-Эрдэнэ нар баялгийн эзэд нь шийдвэр гаргах түвшинд бус хэрэгжүүлэх доод шатанд ажиллаж байгаад эрс шүүмжлэлтэй ханддаг. “Оюутолгой” компанийн төлөөлөн удирдах зөвлөл есөн гишүүнтэй. Үүний гурав нь Монгол Улсыг төлөөлж байна. УИХ-ын гишүүн, Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат “Улсаа төлөөлдөггүй, төрд ажилладаггүй. ТУЗ-ийн гишүүдийг татах ёстой” гэж хэлсэн удаатай.

Ерөнхийлөгчийн зүгээс Оюутолгой төслийн гүйцэтгэх удирдлагын багт Монгол хүн орох учиртайг дэмжиж буйгаа илэрхийлсэн. Мөн Ерөнхийлөгч санхүү, бараа бүтээгдэхүүнийг худалдан авалт, борлуулалт, гэрээ эрх зүй, төслийн үйлчилгээний хэлтэс гээд монгол хүн боломжтой бүх удирдлагад оролцох хэрэгтэйг онцлов. Хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож буй Засгийн газрын дөрвөн сайд “Оюутолгой” компанийн ТУЗ-д тодорхой хугацаатай үүрэг, чиглэл өгч 13 асуудлыг шийдвэрлүүлэх санал тавьжээ. Тухайлбал, Хувь нийлүүлэгчдийн хурлын дэг боловсруулах, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах. Гүйцэтгэх удирдлагын түвшинд оролцоог хангах, дотоодын аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх, Монголын банк, санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх зэрэг шаардлагыг тавьжээ.

Оюутолгой компанийн зүгээс хийсэн мэдэгдэлд “Оюутолгой компанийн ТУЗ есөн гишүүнтэй. Зөвлөлийг Монгол хүн удирддаг. ТУЗ-д багтаж буй “Эрдэнэс Оюутолгой”, “Туркуаз Хилл Ресурс”, “Рин Тинто” компанийн гишүүд бүгд адил тэгш саналын эрхтэй” гэв. Тус мэдэгдэлд “Оюутолгой” компанийн гүйцэтгэх удирдлага Монгол, Англи, АНУ, Австрали, Япон улсын 12 мэргэжилтнээс бүрдсэн хэмээн тайлбарласан юм.

“Оюутолгой” компанийн хувь нийлүүлэгчдийн хурал энэ сарын сүүлээр харилцан тохиролцсоны үндсэн дээр дахин үргэлжилнэ. Шатрын өрөг дээр буй Оюутолгой төслийн нүүдлийг Монголын Засгийн газар болон “Рио Тинто” тэргүүтэй хөрөнгө оруулагч хамтдаа шийдэх учиртай. Түүнээс толгой мэдэн нүүх эрх хэн, хэнд нь байхгүй. Хэлэлцээрт амжилт хүсье. ■

ХУУЛЬ

“ГАМШГИЙН” ХУУЛЬ

Б.ЭНХЦЭЦЭГ

...Уул уурхайн салбарыг ахисан түвшинд хүргэх хууль өнөөдөр “гууль” болох шатандаа явж байгаа ба энэ чигээрээ батлагдвал аврах бус алах хууль болно гэдгийг гаднын мэргэжилтнүүд ч хэлж буй...


Хөрсөн доорх хөрөнгөө зөв хөдөлгөх нь хөгжих гарц ч, буруу залвал улсаа булшлах хараал гэдгийг олон улсын мэргэжилтнүүд сануулсаар байгаа. Тэгвэл манайхан “Улсынхаа эзэн нь байя” гэх уриатайгаар хуулиудаа шинэчлэн засварлах ажлыг өнгөрсөн жилүүдээс эхлүүлсэн гэж үзэж болно. Ингэхдээ эхийг нь эцээж, тугалыг нь тураахгүй хэмээн хэт хүчилсэн, хуурай хуулийн төслүүд боловсруулж буйг амтай болгон ярих болов. Тухайлбал, гурван жилийн өмнө байгаль орчноо хамгаалах нэрийдлээр уул уурхайн салбарынхныг ундууцуулж, малчдын магнайг тэнийлгэсэн урт нэртэй хууль гарсан нь одоо хүртэл шүүмжлэлийн бай болсон хэвээр. Тэгвэл уул уурхайн салбарынхныг айлгасан ахин нэг хуулийн төсөл боловсруулаад байгаа нь Ашигт малтмалын тухай хууль юм.

Он гарсаар дээрх хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотой хэлэлцүүлэг хоёр ч удаа боллоо. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан хуулийн шинэчилсэн найруулгад эдийн засгийн үр ашиг, нийгмийн хариуцлага,байгаль орчин гэсэн гурван үндсэн зарчмыг гол болгосноо өнгөрөгч сарын 18-нд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээн дэх нээлттэй хэлэлцүүлгийн эхэнд хэлсэн. Мөн энэ үеэр хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүн Ц.Даваасүрэн бичил уул уурхайн асуудлыг тус хуульд тусгаагүй бөгөөд тусдаа хуулиар шийдэж болохыг хэллээ. Мөн тэрбээр шинэчилсэн найруулгын онцлогийг “2006 оны хуулийг гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор хийсэн ч одоо цаг үе өөрчлөгдсөн. Хуулийн шинэчилсэн найруулга нь гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоо, хөрөнгө оруулалтын хэрэгцээ багассаны илрэл” хэмээн тайлбарлалаа. Дээрх хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын нэг хэсэг нь хэрэгтэй, хэрэггүй юманд хэт гар дүрсэн хууль болж хэмээн шүүмжилсэн бол төрийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй ч гэж үзэх нөгөө хэсэг байв. Гэвч Цагаан тус хуулийн төслийг эхний хувилбар учир засан сайжруулах бүрэн боломжтойг учирласан билээ.

Ийнхүү санал авч буй Ашигт малтмалын шинэ хуулийн төслийг боловсруулахад үндсэндээ хоёр жил зарцуулсан гэх юм билээ. Уул уурхайн үндэсний ассоциацийн тэргүүн Н.Алгаа “Бид 2011 онд 2006 оны ашигт малтмалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, засан сайжруулах үндэслэл, шаардлагыг албан ёсоор хүргүүлж байсан. Гэтэл зүсээ бүрэн хувиргасан шинэ хууль бичих үндэслэл юу байв гэдэг өнөөдөр ч тодорхойгүй байна” хэмээн Монголын бизнесийн зөвлөлөөс энэ сарын 1-нд уул уурхайн салбарынхны дунд зохион байгуулсан Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэлэлцүүлэг дээр хэлж байсан юм.

Тус хуулийг үг өгүүлбэрээсээ

Монгол Улсын ашигт малтмалын лицензит талбай (2015 оны хэтийн төлөв)



Эх сурвалж: Ашигт малтмалын газар

эхлэн алдаатай, утга зүйн учир дутагдал ихтэй, найруулгагүй болсон гэж хуульчид дүгнэж байна. Монгол Улсын Үндсэн хуультай зөрчилдсөн байж болох 15 заалт байгаагаас гадна бусад хуультай хагаралдаж, давхардсан заалт олон байгаа аж. Өөрөөр ойлгогдох утга бүхий 24 заалт байгаа бол шууд уншаад ойлгохооргүй заалт 178 байгааг “МІН” компанийн хуулийн зөвлөх Б.Баярмаа хэлсэн. Мөн тэрбээр хэлэхдээ “Хуулийн төсөл боловсруулахын өмнө үндэслэл шаардлагаа тодорхойлж, үзэл ажиллах ямар ч нөхцөл байхгүйг хурцаар шүүмжилж байв. Мөн шинээр газрын хэвлийд хөл гишгэхийг эрмэлзэгчдийн хувьд бүр ч “мордохын хазгай” болохоор хууль байна гэцгээж байсан юм. ELC хуулийн фирмийн гүйцэтгэх захирал Б.Баяр “Ашигт матмалын тухай хуулийн шинэчилсэн хувилбараас үзэхэд компаниуд ашигтай ажиллах, гаднын хөрөнгө оруулагчдаас хөрөнгө татах ямар ч боломжгүй байхаар байна. Монголын уул уурхайн компаниудын хувьд IPO босгож, санхүүжих нь нэн чухал. Хэрэв



баримтлалаа тогтоодог. Гэвч би өнөөдрийг хүртэл энэ хуулийн төслийн үзэл баримтлалыг олж хараагүй. Иймд үүнийг үзэл баримтлалгүй тунхагийн шинжтэй хууль гэж харж байна. Хуульд нэг нэр томъёог нэг л утгаар хэрэглэдэг. Гэтэл хоёрдмол санаа бүхий заалт, нэр томьёо олон байгаа юм. Иймд боловсруулалтын хувьд тааруухан төсөл болсон гэж дүгнэхээр байна” гэв. Жишээлбэл, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн хуулийн төслийн 25.4-т “Олборлолтын тусгай зөвшөөрлийг 20 жил “хүртэлх” хугацаагаар олгоно” гэж заажээ. Гэтэл хүртэлх гэдэг хэдэн жил ч байж болохыг илтгэх ба хэн нэгэн эрх мэдэлтэн үүнийг үзэмжээрээ шийдэх үндэслэл болохоор байна.

Дээрх хоёр хэлэлцүүлгээс үзэхэд ихэнх хүмүүс уг хуулийн ойлгомжгүй бүрхэг байдал, хэрхэн хэрэгжихийг маш бага тайлбарласан зэрэгт шүүмжлэлтэй хандаж байна. Салбарынхны зүгээс төрийн оролцоог хэр хэмжээнд байлгах вэ гэдэгт хуваагдмал байр суурьтай байсан ч гадаад, дотоодын гэлтгүй нийт компаниудын хувьд дээрх хуулийн хүрээнд ашигтай Монголын Засгийн газар 51 хувийг нь эзэмших ёстой болвол, компаниудын хувьд санхүүжилт олно гэдэг боломжгүй асуудал. Тухайлбал, банкууд тийм эрсдэл хүлээхгүй” гэв.

Монголын Геологийн холбооны гишүүд саналаа нэгтгэж Геологийн судалгааны тухай, Уул уурхайн тухай гэсэн хоёр тусдаа хууль боловсруулах нь оновчтой гэж үзэж буйгаа илэрхийлсэн. Шинэ хуулиар компаниудын хайгуулын ажилд зарцуулагдах мөнгөн дүнг хамгийн доод хэмжээгээр тооцсон ч улсын хөрөнгөөр хийдэг хайгуулын зардлаас 10 дахин их хөрөнгө гарахаар байна. Гэтэл хайгуулын зардал харилцан адилгүй байдаг гэдгийг “Магма Майнз” компанийн захирал Э.Батмөнх илтгэлдээ онцолж байсан. Геологичдийн зүгээс “Хуулийн төслийн зорилго нь геологи уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжих гэсэн атлаа агуулга нь геологийн салбарыг сөхрүүлэх нь. Геологийн салбарын бодлого, хэтийн зорилт огт алга. Мөн дундаж орлоготой, мэргэжлийн компаниуд тусгай зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулах ямар ч боломжгүй болж” гэдгийг хэлж байна.

Ашигт малтмалын тухай хуулийн төслийн сайн талууд

- Бүх шатанд хариуцлагыг нэмэгдүүлсэн
- Байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой заалтуудыг тодорхой болгох гэж оролдсон
- Эрдэс баялгийн салбарт Монгол хүний хувь оролцоог тодорхой болгохоор заасан ч маш болхи тусгаж өгсөн.
- Орон нутагтай харилцах тал дээр дэвшил гаргах гэж хичээсэн (Орон нутаг хөгжүүлэх гэрээ гэх мэт)
- Нийт эрэл хайгуулын ажил, бараа үйлчилгээний 60 хувийг дотоодын аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэхээр заасан
- Ордыг сорчилж олборлохыг хориглосон
- Эрдэс баялгийн биржтэй болохоор тусгасан

Байж боломгүй заалтууд

- Стратегийн орд гэсэн ойлголт байдаггүй, харин стратегийн ашигт малтмал гэж ойлголт бий.
- Хайгуулын тусгай зөвшөөрлийг зөвхөн сонгон шалгаруулалтаар олгохоор болсон нь тойм судалгааг хувийн хөрөнгөөр хийх утга учрыг алдагдуулж, геологи хайгуулын ажлыг эхлүүлэх боломжгүй болгож байна.
- Газрын ховор элемент гэдэг ойлголтыг олон янзаар тайлбарласан байдаг, элементүүдээр нэр зааж өгөх шаардлагатай.
- Ажил гүйцэтгэх зөвшөөрөл гэж огт байж болохгүй. Эрлийн, хайгуулын гэж авч байгаа зөвшөөрөл өөрөө ажил гүйцэтгэх зөвшөөрөл.

Эх сурвалж:
Монголын Геологийн холбоо

Уул уурхайн салбарыг ахисан түвшинд хүргэх хууль өнөөдөр “гууль” болох шатандаа явж байгаа ба энэ чигээрээ батлагдвал аврах бус алах хууль болно гэдгийг гаднын мэргэжилтнүүд ч хэлж буй. “Махонни Лиотта” хуулийн фирмийн хуульч Жеймс Лиотта “Ашигт малтмалын тухай шинэ хуулийн төслийг засварлахад ч хэцүү. Дахин шинийг бичих хэмжээнд болсон” хэмээсэн юм.

Гэсэн ч Монгол Улсад орж ирэх хөрөнгө оруулалтын хэмжээ эрс буурч буй энэ үед дахин шинийг бичээд суух цаг бий юү. Манай нийт хөрөнгө оруулалтын хэмжээ Оюутолгой төсөлтэй шууд хамааралтай. Тухайлбал, Оюутолгой төслийн нийт санхүүжилт гадаадын хөрөнгө оруулалтын 63 хувийг эзэлж байна. Тэгвэл Оюутолгойн төслийн хөрөнгө оруулалт эцэслэгдэж буй ирэх жилүүдэд гадаадын хөрөнгө оруулалт ямар сувгаар орж ирэх вэ. Хөрөнгийн шинэ урсгалыг хааж, боосон олон хуулиудын аль цоорхойгоор гадаадын хөрөнгө оруулалт хэр хэмжээнд орж ирэх вэ гэдэг асуулт ургаж байна.

Өнгөрсөн онд нийт нутгийн 13 хувийг хамарсан 3636 лиценз олгосон бол үүнээс газар нутгийн 0.5 хувьтай тэнцэх 1200 лиценз нь ашиглалтынх байна. Ирэх хоёр жилд хайгуулын зөвшөөрөл нэмж олгохгүй бол лицензтэй талбай дараа онд газар нутгийн долоон хувь, 2015 онд таван хувь болтлоо буурах аж. Үүнийг дагаад мөн гадаадын хөрөнгө

БАЯЛГИЙН ХУВААРИЛАЛТ

ТӨСВИЙН ЭРҮҮЛ БОДЛОГО БА БАЯЛГИЙН САНГИЙН ҮҮРЭГ



ЯАН ХАНСЭН
/АХБ-ны Суурин төлөөлөгчийн газрын ахлах эдийн засагч/

Монгол Улсын эдийн засгийн дунд хугацааны хэтийн төлөв нь хөгжлийнхөө эхэн шатанд явж буй Тавантолгойн нүүрсний уурхай болоод 2013 оны дундуур эхлэхээр төлөвлөсөн Оюу Толгойн зэс, алтны уурхайн үйлдвэрлэлээс үүдэн нэлээд таатай байх бололтой. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц нь эдийн засгийн хөгжилд онцгой боломж олгодог хэдий ч бодит амьдрал дээр байдал өөр байх нь цөөнгүй. Төсвийн ухаалаг бодлоготой уялдуулан Баялгийн сан байгуулах нь “Баялгийн хараал”-ыг “Баялгийн ерөөл” болгох эдийн засгийн бодлогын чухал арга хэмжээ юм.

“Баялгийн хараал”-ын хандлагаас харвал байгалийн нөөц ихтэй орнууд нь нөөц багатай орнуудаас илүү хурдтай хөгжиж чаддаггүй, хүний хөгжлийн үзүүлэлтүүд нь өндөр түвшинд байдаггүй аж. Гэхдээ байгалийн нөөц ихтэй орнууд баялгийн хараал хүрч, мордохын хазгай болж, дампуурах жамтай гэж үзэж болохгүй. Норвеги, Ботсван, Чили зэрэг байгалийн нөөц ихтэй хэд хэдэн орон нөөц баялгийнхаа ачаар хөгжил дэвшилд хүрээд байгаа билээ.

Баялгийн хараалыг ерөөл болгох нь

Байгалийн баялгаас орж ирж буй асар их хэмжээний орлого нь эдийн засгийн бодлого боловсруулагчдад ихээхэн бэрхшээл учруулдаг төдийгүй үүнийг байгалийн нөөцийн хараал тусах нэг том шалтгаан хэмээн үздэг. Баялгийн хараалыг ерөөл болгоход тулгардаг гол бэрхшээл бол уул уурхайгаас орж ирж буй асар их хэмжээний орлогыг төсвийн ухаалаг бодлогоор дамжуулан, үр ашигтай зарцуулах явдал юм. Энэ бол уул уурхайг түшиглэсэн эдийн засгийн хөгжил, баялгийн менежментийн талаарх цуврал дөрвөн нийтлэлийн хоёр дахь нь юм. Энэхүү нийтлэлийн зорилго нь байгалийн нөөц ихтэй хөгжиж буй орнуудад зориулсан зөв зохистой төсвийн бодлогын хүрээний гол элементүүдийг тодорхойлж, Баялгийн сангийн гүйцэтгэх үүргийг онцлоход оршино. Гурав дахь нийтлэл нь улс орнууд макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд Баялгийн сангийн оруулах хувь нэмрийг нарийвчлан судалж, улмаар холбогдох загваруудыг танилцуулна.

оруулалт буурах нь дамжиггүй. Уул уурхайн компаниуд анхнаасаа баян байдаггүй. Тиймээс ч компаниуд хайгуулын шатанд цаашдын үйл ажиллагаагаа хангах хөрөнгөө банкны зээлээр эсвэл хөрөнгийн зах зээл дээр босгодог. Гэтэл одоогоор дэлхийн биржүүд дээрх Монголын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьцаа 60-70 хувийн уналттай байна. Ийм нөхцөлд хөрөнгө оруулалт татахад нэн хүндрэлтэй. Тиймээс алдагдал хүлээсэн хөрөнгө оруулагчид хувьцаанд хөрөнгө оруулалт хийх сонирхолгүй байх нь мэдээж. Дээр нь банкны зээл хэмээх хөрөнгө босгох ганц боломжийг “горилох” бус олон улсын жишгээр хөрөнгийн захад хувьцаа гаргах хэлбэрээр хөрөнгө босгох боломжийг боомилох үүд мөн л дээрх хууль болох нь гэдгийг хүмүүс хэлж байлаа.

Хөлд орж буй Монголын хөрөнгийн биржийн хөгжлийг чиглүүлнэ гэж үзэж байсан Ашигт малтмалын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан Стратегийн ордуудын 10 хувийг дотоодын хөрөнгийн биржээр арилжих заалтыг авчихлаа. Хөлийг нь хугалчихаад одоо босоод яв гэснээс ялгаагүй үйлдэл болж буйг салбарынхан ч хэлж буй. “Алтан Дорнод Монгол” компанийн гүйцэтгэх захирал Б.Болд “Ашигт малтмалын салбарынхан гэхээрээ л асар их мөнгөтэй байдаг юм шиг санаад уг хуулийг хийчихэж гэж ойлгож байна. Мөн дотоодын хөрөнгийн бирж дээр стратегийн ордын 10 хувийг гаргах заалтыг хуулиас аваад хаячихлаа. Одоо тэгээд яахав. Хүй нэгдлийн үе рүүгээ буцаж, малаа маллахаас” хэмээн өгүүлсэн. Энэ бүхнийг гадаад, дотоодынхон Монголын улс төр, хууль эрх зүйн тогтворгүй орчинтой холбон тайлбарлаж байна.



Одоо мөрдөгдөж буй 2006 оны Ашигт малтмалын тухай хуульд эрэл хайгуулын үйл ажиллагаа явуулахад нийт 11 зөвшөөрөл авч байсан бол шинэ хуулийн төслөөр 28 болж нэмэгджээ. Монголын бизнесийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Жим Двайер“ Шинэ хуулийг сайжруулах шаардлага асар их байна. Одоогийн хуулиар, хайгуулын ажил бүрэн зогсохоор байгаа юм. Засгийн газрын өмчлөл болон 10 жил өмчлөх эрхтэй холбогдсон тодорхойгүй заалтууд нь том төслүүдэд санхүүжилт татах боломжгүй болгож байна. Уг хуулийн сайн тал нь доторх агуулгадаа бус Ерөнхийлөгчийн Тамгын газар иргэдээс засан сайжруулах санал, шүүмжлэлээ чөлөөтэй илэрхийлэхийг хүсэж байгаа нь юм. Ийм үйл явдал өмнө нь бараг байгаагүй” гэв.

Дээрх хуулийг “Гамшгийн хууль” гэж нэрлэх хүмүүс ч цөөнгүй. Нөхөн сэргээлт, байгаль орчин, хариуцлагын асуудлыг чамгүй сайн тусгаж өгсөн ч жижиг, дунд хэмжээний компаниуд хуулиараа шахагдаж, өмчөө төрд булаалгах бүрэн үндэслэл бүрдсэн ба яаж хэрэгжих нь тодорхойгүй бүрхэг заалт олонтой хууль болсон гэдгийг мэргэжилтнүүд хэлж байна. Гадаад, дотоодын бизнес эрхлэгчдийн алинд ч хууль, эрх зүйн орчин амин чухал. Гэтэл Улаанбаатарын агаар шиг бизнесийн орчноос гаднынхан байтугай элэг нэгтнүүд нь ч болгоомжлон, дайжихад хүрэх бололтой. ■

Байгалийн нөөцийн орлогыг хэрэглээнд зарцуулах нь баялгийг багасгадаг

Санхүүгийн цэвэр баялаг, байгалийн нөөц баялгийн нийлбэрийг төрийн баялаг гэж үзэж болно. Учир нь нөхөн сэргээгдэхгүй байгалийн нөөц нь баялгийн нэг хэсэг бөгөөд байгалийн нөөцөөс олох орлого нь өөрөө ашиг биш юм. Энэ нь ердөө л эрдэс баялаг юм уу газрын тос зэрэг газрын гүнд байсан баялгийг газар дээр гаргаж бэлэн мөнгө болгох, өөрөөр хэлбэл байгалийн нөөцийг өөр хэлбэрийн баялаг болгох үйл явц юм. Байгалийн нөөцийн орлого нь бие даасан хэлбэрээрээ (тухайлбал татвар, роялти, төлбөр, бонус, ногдол ашиг) бусад орлоготой адилгүй бөгөөд урт хугацаанд төсвийн тогтвортой байдлыг хангаж, үе үеийнхэнд баялгийг тэгш хүртээхийн тулд энэхүү орлогыг зарцуулахаасаа илүү хуримтлуулах нь чухал. Иймд байгалийн нөөцөөс хамааралтай улс орны төсвийн бодлого нь төсвийн ерөнхий тэнцэлийг бус харин байгалийн нөөцийн бус улсын төсвийн тэнцэл буюу байгалийн нөөцийн бус орлого болоод төсвийн бүх зардлын зөрүүнд түлхүү анхаарах хэрэгтэй.

Байгалийн баялгаас хамааралтай орны төсвийн бодлогын гол бэрхшээл нь зарцуулахаасаа илүү хуримтлуулах шаардлагатай байгалийн нөөцийн орлогын хэмжээг тодорхойлох явдал байдаг. Иймд нийтлэлийн дараагийн хэсэгт байгалийн нөөц ихтэй хөгжиж буй орнуудын төсвийн бодлогын хүрээний гол зарчмуудыг (i) урт хугацааны нөөц ашиглалт, (ii) богино болон дунд хугацааны бизнесийн цикл гэсэн цаг хугацааны хоёр хүрээнд авч үзэв.

Урт хугацаан дахь сангийн бодлого

Төсвийн бодлогыг зөв зохистой байлгах тухай маргаан, хэлэлцүүлэгт тогтмол орлогын таамаглалын аргачлал давамгайлдаг. Энэ аргачлал нь байгалийн нөөц баялгийг бүхэлд нь санхүүгийн хөрөнгө болгон хувиргаж, хуримтлалын сан буюу баялгийн санд хуримтлуулж, байгалийн нөөц баялгийг бүхэлд нь хойч үедээ хадгалдаг. Харин уг хөрөнгөөс олох ашиг орлогыг, төсвийн зардлыг санхүүжүүлэхэд зарцуулдаг. Иймд тогтмол орлогын таамаглалын аргачлалаар бол Баялгийн санд хуримтлуулсан хөрөнгөөс олох ашгаас улсын төсөвт тогтмол нэмэлт орлого орох учиртай.

Байгалийн нөөцийн үйлдвэрлэлээс ирээдүйд, төсөвт орох орлогын (нөөцтэй холбоотой зардлыг хасч тооцоно) өнөөгийн хямдруулсан үнэ цэнэ байгалийн нөөц баялагт шингэсэн байдаг. “Тогтмол орлого”-ыг нөөц баялгийн үнэлгээнд тулгуурлан тооцоолж болно. Засгийн газрууд байгалийн нөөц баялгийнхаа бодит хүүгийн орлогыг хүртэж, байгалийн нөөцийн бус төсвийн алдагдлыг санхүүжүүлэх нэмэлт тогтмол орлоготой болтлоо байгалийн нөөцөөс олсон орлогоо зарцуулж болно. Өөрөөр хэлбэл, төсвийн бодлого нь байгалийн нөөц баялгаас олж буй ашигтай тэнцүү хэмжээний байгалийн нөөцийн бус тогтмол алдагдлыг санхүүжүүлж болно. Энэ аргачлал нь байгалийн нөөц барагдахад түүнийг нөхөх санхүүгийн нөөц хуримтлалыг үүсгэх зорилготой. Байгалийн нөөцийн бус төсвийн алдагдал нь байгалийн нөөц баялгийн ашгаас давбал эсрэгээрээ баялаг барагдаж, төсвийн бодлого тогтворгүй болдог.

Хөгжиж буй орнуудад ядуурлыг бууруулах, мөн нэн тэргүүнд тавигдаж байгаа хөрөнгө оруулалтыг хийх шаардлага байдаг

Эрдэс баялгийг цэвэр хөрөнгө мэт удирдан зарцуулж, үнэ цэнийг нь хадгалж, ашгийг нь хүртэж хэрэглэх нь хөгжлийн өндөр түвшинд хүрсэн (Норвеги шиг) орны хувьд оновчтой бодлого байж болох юм. Гэвч ядуурлын түвшин өндөр, төрийн суурь үйлчилгээнүүдийг сайжруулж, хүн болоод бодит капиталд хөрөнгө оруулалт хийх хэрэгцээ шаардлага ихтэй хөгжиж буй орнуудын нөхцөл байдалд энэ аргачлал нь тийм ч тохиромжтой бус. Хөгжиж буй орнууд санхүүгийн хөрөнгөө хуримтлуулахаас илүү нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхийн тулд юуны түрүүнд уул уурхайн болоод уул уурхайн бус бусад салбаруудаа хөгжүүлэх, дэд бүтцэд төрөөс хөрөнгө оруулалт хийх, боловсрол, эрүүл мэндийн салбарт хөрөнгө оруулах замаар дотоодын бодит капитал, хүний капиталаа бэхжүүлэхийг чухалчилдаг.


Иймд хөгжиж буй орнуудад тогтмол орлогын таамаглалын аргачлал бус харин байгалийн нөөцийн орлогыг юуны түрүүнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэхэд түлхүү зарцуулдаг илүү уян хатан аргууд хэрэгтэй. Хуримтлуулсан суурь баялаг буюу тогтмол орлогын таамаглалын аргаар эрдэс баялгийг бүхэлд нь санхүүгийн хөрөнгө болгон хувиргаж байгалийн нөөцийн орлогоос ахиухан хэсгийг ядуу иргэдэд улсын төсвөөс зарцуулж, харин илүү баян чинээлэг хойч үеийнхэн баялгаас харьцангуй бага хувь хүртдэг. Өөрөөр хэлбэл, байгалийн нөөцийн бус төсвийн алдагдал нь эхэн үедээ байгалийн нөөц баялгаас олж буй ашгаас давж болно гэсэн үг.

Инфляциас сэргийлэх нь

Гэтэл байгалийн нөөцөөр санхүүжүүлж буй зардлыг (их хэмжээгээр) өнөө үед нэмэгдүүлэхийг эсэргүүцдэг эдийн засагчид ч бас байдаг. Тэд зардлыг хэт нэмэгдүүлбэл тэр их зардлыг шингээх нь бэрхшээлтэй гэж үздэг. Өсөн нэмэгдэж буй зардлыг шингээх Засгийн газрын чадвах, нэн ялангуяа хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авалт, төслийн менежментийн чадавх болоод эдийн засгийн чадавх нь хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулж, үргүй зардлыг өсгөн, инфляцийн дарамтыг нэмэгдүүлдэг аж. Зардал шингээх чадавх багатай улс орнууд байгалийн нөөцөөр санхүүжүүлж буй зардлыг аажмаар нэмэгдүүлэхийн сацуу төсвийн санхүүгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлж улмаар дотоодын ханган нийлүүлэлтийн чадвахыг сайжруулдаг. Байгалийн нөөц ихтэй улс, орнууд орлогоо хэтрүүлэн зарцуулж, хэт бага

хуримтлал үүсгэснээс бэрхшээлүүд үүсдэг нөхцөлийг баялгийн хараал хэмээн тайлбарладаг болохыг анхаарах нь чухал.

Байгалийн баялаг ихтэй болон баялаггүй орнуудын нийт төсвийн тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн төсөөлөл ба Олон улсын валютын сангийн тооцоолол

Улсын баялгийг баялгийн санд хуримтлуулах нь

Баялгийн сан нь урт хугацааны төсвийн бодлогын хүрээнд баялаг хуримтлуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ингэхдээ гадаадын санхүүгийн хөрөнгөд, хөрөнгө оруулах замаар байгалийн нөөцийн орлогыг байгалийн нөөц барагдсаны дараа хойч үеийнхэнд орлого өгөх санхүүгийн хөрөнгө болгодог. Дотоодын эдийн засгийг байгалийн нөөцийн орлогын тогтворгүй байдал нийт эрэлтийн сөрөг нөлөөнд автуулахгүйн тулд санхүүгийн хуримтлалаар гадаадад хөрөнгө оруулах нь чухал.

Баялгийн санг үр нөлөөтэй байлгахын тулд үр ашигтай төсвийн бодлогын хүрээнд зөв зохистой төсвийн зохицуулалтаар дамжуулан байгалийн нөөцийн бус төсвийн алдагдлыг шийдвэрлэх, төсвийн урт хугацааны бодлогын зорилтод тусгах ёстой. Энэ тохиолдолд төсвийн бодлого нь байгалийн нөөц, баялгийн ашигтай тэнцүү нөөцийн бус тогтмол алдагдлыг нөхөхөд чиглэнэ. Үр ашигтай төсвийн бодлогын хүрээнд тусгагдаагүй, төсвийн бодлогын тодорхой зорилтгүй, ердөө л хөрөнгийн орж гарах урсгалыг зохицуулах төдий Баялгийн сан нь үр ашиггүй. Учир нь Засгийн газар Баялгийн санд хийх шаардлагатай санхүүжилтыг зарим тохиолдолд бусдаас зээлдэг.

Сангийн богино хугацааны бодлого: эдийн засгийн тааламжтай үед хуримтлуулах, тааламжгүй үед зарцуулахад чиглэгдэх

Тогтмол орлогыг тооцож ашиглах аргачлалын дагуу тодорхойлогдсон урт хугацааны төсвийн бодлогод эдийн засгийн цикл дэх богино болоод дунд хугацааны асуудлуудыг тусгах хэрэгтэй. Байгалийн нөөц ихтэй оронд байгалийн нөөцийн үнийн хэлбэлзлийг зохицуулахын тулд сангийн оновчтой, мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлэх явдал юм. Өөрөөр хэлбэл, гэнэтийн үнийн өсөлтийн үед байгалийн нөөцтэй холбоотой нэмэлт орлогыг хуримтлуулж, гэнэтийн үнэ бууралтын үед уг хуримтлалыг ашигладаг байхад оршино. Ийм төсвийн бодлого нь байгалийн нөөцийн үнийн хэлбэлзлээс үүсч буй макро эдийн засгийн тогтворгүй байдлыг сааруулдаг.

Байгалийн баялгаас хамааралтай улс орнуудад байгалийн нөөцийн үнийн тогтворгүй байдал, хэлбэлзэл нь сөрөг үр дагавар авчирдгийг баталсан олон баримт бий. Бусад төрлийн орлоготой харьцуулахад байгалийн нөөцийн орлого нь тодорхойгүй хэрнээ ихэвчлэн тогтворгүй байдаг. Энэ нь олон улсын байгалийн нөөцийн үнийг урьдчилж харах боломжгүй, мөн ихээхэн хэлбэлздэгтэй холбоотой. Байгалийн нөөцийн үнийн хэт тогтворгүй байдал нь Голланд өвчнийг үүсгэдэг гол шалтгааны нэг.

Олон улсын шилдэг туршлагад тулгуурласан Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын тухай хууль энэ жилээс хэрэгжихээр болсон

Байгалийн нөөцийн үнийн хэт тогтворгүй байдлын улмаас богино болоод дунд хугацааны төсвийн зохицуулалтыг хийх шаардлагатай болдог. Төсвийн нийт тэнцэлээс илүү тэнцвэржүүлсэн төсвийн тэнцэл (буюу тэнцвэрт байдал), төсвийн орлогыг тооцоход ашигладаг байгалийн нөөцийн үнэд суурилсан бус харин урт хугацааны дунджид суурилсан төсвийн зохицуулалт байдаг. Энэ зохицуулалтын үед төсвийн бодлогын зорилт нь тэнцвэржүүлсэн төсвийн тэнцэлд хүргэх явдал байдаг. Энэхүү төсвийн зохицуулалт нь байгалийн нөөцийн орлогыг тэгшитгэж, төсвийн зардлыг байгалийн нөөцийн үнийн хэлбэлзэлээс хамгаалдаг. Төсвийн орлогыг Төсвийн тогтворжуулалтын сангийн дэмжлэгтэйгээр тэнцвэржүүлдэг. Төсвийн тогтворжуулалтын сан нь төсвийг байгалийн нөөцийн үнийн тогтворгүй байдлаас хамгаалж, төсвийн бодлого болоод эдийн засагт үзүүлэх тогтворгүй орлогын нөлөөг бууруулж, төсвийн орлогын тогтвортой байдлыг хангах зорилготой. Байгалийн нөөцийн үнэ “өндөр” байх үед тус сан нь орлого хуримтлуулж, харин үнэ “буурах” үед уг сангийн хөрөнгийг төсөвт зарцуулдаг. Хуримтлалын сан буюу Баялгийн сан нь хойч үедээ баялаг хуримтлуулах зорилготой. Үнэд суурилсан/төсвийн тогтворжуулах зорилт бүхий зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ улсын өрийн дээд хязгаарыг тогтоож, төсвийн зардлын өсөлтийг зохицуулах зэрэг төсвийн тогтвортой байдлыг хангах нэмэлт арга хэмжээнүүдийг авдаг.

Богино болоод дунд хугацааны Монгол Улсын өнөөгийн төсвийн хүрээг 2010 оны зургадугаар сард баталж, энэ оноос бүрэн хэрэгжиж байгаа Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд тодорхойлсон. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар төсвийн бүтцийн алдагдал, өр, төсвийн зардлын өсөлт зэрэгт дээд хязгаарыг тогтоож, Төсвийн тогтворжуулалтын санг байгуулсан бөгөөд Засгийн газар одоо Баялгийн сан бүхий урт хугацааны төсвийн бодлогын хүрээг боловсруулж байна. ■

ДАВОСЫН ЧУУЛГАН

ИРЭХ ЖИЛИЙН ЧУУЛГАНААР МОНГОЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭНЭ

И.ОТГОН

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж тэргүүтэй албаныхан өнгөрсөн сарын 23-27-нд Давосын дэлхийн эдийн засгийн чуулганд амжилттай оролцоод ирсэн билээ. Амжилттай гэдэг үгийг зүгээр хэлсэнгүй. Өөрөөр хэлбэл, Монгол Улс энэ удаагийн Давост манлайлал, санаачилга, оролцоогоор тод ялгарсан гэж хэлж болно. Дэлхийн улс төр, эдийн засаг, бизнесийн томоохон төлөөллүүд цуглардаг тус чуулганы үеэр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Анан, Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын дарга Клаус Шваб гэсэн нэр нөлөө бүхий хүмүүс Монголын тухай Шинэ боломж, өөдрөг төсөөллөөр дүүрэн, Ардчилалд амжилттай шилжсэн гээд бусдад үлгэр дуурайлал болох сайн жишээ бийг онцлон тэмдэглэсэн нь бахархуштай. Манай сэтгүүлч тус чуулганд оролцсон Гадаад харилцааны сайд Л.Болдтой ярилцсаныг хүргэе.

-Давос 2013 чуулга уулзалтад оролцсон хүний хувьд Та дэлхийн эдийн засгийн төлөв, цаашдын чиг хандлага ямар байх талаар товчхон сонирхуулахгүй юу?

-Энэ удаагийн чуулга уулзалтын онцлог гэвэл өмнөхөөс нэлээд өөдрөг уур амьсгалтай боллоо. Энэ нь Евро бүсийн өрийн хямралын хамгийн хүнд үе өнгөрсөн, мөн АНУ санхүүгийн хямралд орохоос сэргийлж чадсантай холбоотой. Өнгөрсөн оны чуулга уулзалтаар еврогийн валютын холбоо задарч болзошгүй гэсэн айдас давамгайлж байсан. Евро бүсийн орнууд хамтын хүчээр үүнээс сэргийлж чадлаа.

Гэхдээ дэлхийн эдийн засаг эмзэг хэвээр байгаа нь мэдрэгдэж байсан. Олон улсын санхүүгийн зах зээлийн байдал сайжирсан ч эдийн засгийн бодит секторт хараахан нөлөөлөөгүй байна. Хямралаас сэргийлсэн ч суурь асуудлууд шийдэгдээгүй хэвээр. Чуулганы үеэр нэгэн эдийн засагч “Цаг агаар ялимгүй дулаарсан ч, нар гарахад өдий байна” гэж хэлснийг энд тэмдэглэмээр байна.

Эдийн засгийн уур амьсгал сайжирсанд санаа амарч, шинэчлэлийн үйл хэргээ сааруулж болохгүй хэмээн олон улсын санхүүгийн байгууллагын удирдлага, шинжээчид онцолж байсан. “Тайвширч болохгүй” гэж Олон улсын валютын сангийн дарга Кристин Лагард ч удаа дараа анхааруулж байлаа. Ер нь бол хямралын уур амьсгал намжсан нь тайвширах зүйл биш гэдэг нь чуулга уулзалтаас гарсан гол санаа юм.

Цаашдын чиг хандлагын хувьд дэлхийн эдийн засаг зогсонги байдлаас аажмаар гарч, энэ онд болон ирэх жил илүү хурдацтай сэргэх төлөвтэй байна. Олон улсын валютын сангийн тооцоогоор дэлхийн эдийн засаг энэ жил 3,5 орчим хувиар өсөхөөр байна. Энэ нь өмнөх оныхоос ахисан үзүүлэлт юм.

Шинээр хүчирхэгжиж буй орнуудын эдийн засаг хурдтай өсч, харин өндөр орлоготой орнуудын өсөлт саарах хандлагатай байна.

-ОХУ-ын эдийн засгийн төлөвийг судалсан хөндлөнгийн шинжээчдийн үнэлгээг Давост танилцуулсан. Үнэлгээгээр тус улсын эдийн засаг хямралд өртөж болзошгүй төлөв гарсан. Хойд хөршийн эдийн засгийн энэхүү таагүй байдал манайд хэрхэн нөлөөлөх бол.

-Миний бие тус чуулганы ОХУ-ын хөгжлийн чиг хандлагыг хэлэлцсэн нэгдсэн хуралдаанд оролцсон. Манай хойд хөршид ялангуяа засаглалтай холбоотой тулгамдсан асуудал байгааг судалгаа харууллаа. Гэхдээ тус улс эдийн засгаа төрөлжүүлэхэд түлхүү анхаарч ажиллаж байгаа нь нэгдсэн хуралдаанаас харагдсан. ОХУ эдийн засагтаа бүтцийн өөрчлөлт хийж, эмзэг байдлаа даван туулна гэдэгт бид итгэлтэй байна.

-Давосын түншлэлийн хүрээнд бие даасан шинжээчдийн баг Монголд ажиллаж, 2030 онд Монголын хөгжлийн төлөв ямар байх тухай судалгааг гаргахаар болсон гэсэн. Энэ баг хэзээ ирэх вэ?

-Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын бие даасан шинжээчдийн баг Монголын нийгэм, эдийн засгийн талаар судалгаа гаргахаар ирэх сард манай улсад ирж,



Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Гадаад харилцааны сайд Л.Болд, Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын дарга Клаус Шваб нар. 2013.01 сар

Монголын эдийн засгийн ээлжит чуулганы үеэр хөрөнгө оруулагч, сэтгүүлч, нийгмийн зүтгэлтэн нийлсэн 100 хүнээс ярилцлага авна. Энэ судалгаа нь ирэх есдүгээр сард Улаанбаатарт болох “Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт ба Монгол Улсын стратегийн яриа хэлэлцээ” арга хэмжээний үеэр ярих тулгуур материал болох учиртай юм.

-Давосын чуулга уулзалтад Ерөнхийлөгчийн Тамгын газар, Гадаад харилцааны яамны зүгээс Монгол Улсыг сурталчлахад нэлээд анхаарсан. Чуулганд оролцогчид Монголын талаарх мэдээллийг хэр сонирхож байна вэ?

-Бид танай “Mongolian Economy” сэтгүүлийн Давосын чуулганд зориулсан тусгай дугаар болон Монголын тухай бусад материалыг чуулга уулзалтад оролцогчдод тараасан. Манай улсын эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын таатай орчин зэрэг нь олон улсын анхаарлыг ихэд татах болсон тул Давосын чуулганд оролцогчид Монголын талаарх мэдээллийг нэлээд сонирхож байсан. Чуулга уулзалтаар тогтмол зохион байгуулдаг “Mongolia Night” хүлээн авалтын үеэр манайхыг илүү сонирхож байгаа нь илт байсан. Мөн манай хүлээн авалтад 360 гаруй зочин оролцсон. Тэдний дунд Азийн хөгжлийн банкны ерөнхийлөгч Х.Курода, Олон улсын улаан загалмай, хавирган сар нийгэмлэгүүдийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Б.Гелета, Швейцарын хөгжил, хамтын ажиллагааны агентлагийн ерөнхий захирал М.Дахинден, “Арева” группын ерөнхийлөгч Л.Урсель, Бахрейны газрын тосны корпорацийн захирал Шейх Салман Ал Халифа, “Credit Suisse” банкны дэд ерөнхийлөгч К.Вагнер, “CNBC International”-ийн дэд ерөнхийлөгч Ж.Касей, Харвардын их сургуулийн Жон Кеннедийн нэрэмжит Төрийн удирдлагын сургуулийн захирал Д.Эллвүүд, Нобелийн шагналт эдийн засагч Жозеф Штиглиц, Тони Блейрийн албаны дарга С.Криесел зэрэг нэр нөлөө бүхий хүн байлаа. Хүлээн авалтын үеэр тэд Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой уулзсан.

-Улаанбаатарт ирэх есдүгээр сард болох “Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт ба Монгол Улсын стратегийн яриа хэлэлцээ”-ний онцлог, ач холбогдол юу байх вэ?

-“Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт ба Монгол Улсын стратегийн яриа хэлэлцээ” (World Economic Forum Mongolia Strategic Dialogue Event) олон талт дугуй ширээний уулзалтаар манай улсын эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, хэтийн төлөвийг хэлэлцэх юм. Дэлхийн эдийн засгийн чуулганаас ийм төрлийн дугуй ширээний уулзалт өнгөрсөн онд Москвад зохион байгуулсан бөгөөд уулзалтын үр дүнг Давосын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн юм. Үүнтэй мөн адил Улаанбаатарын дугуй ширээний уулзалтын дүнг 2014 оны Давосын чуулга уулзалтын нэгдсэн хуралдаанаар танилцуулах юм.

Улаанбаатарын дугуй ширээний уулзалт нэг талаас манай бодлого боловсруулагчид олон улсын нэр хүндтэй шинжээчдийн санаа оноог сонсох, хамтдаа шийдэл боловсруулах, нөгөө талаас бизнес, хөрөнгө оруулалтын орчны талаар гадаадын улс орон, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдад зөв ойлголт өгөх ач холбогдолтой юм. ■

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН



Х.ХУЛАН

Ирэх сарын 4-5-нд Төрийн ордонд болох Монголын эдийн засгийн чуулганд дотоод, гадаадын олон төлөөлөгч оролцох бөгөөд нэгэн хүндтэй зочныг урьж, оролцуулахаар байгаа аж. Тэр хүн бол Голландын Ерөнхий сайд асан Вим Кок юм. Тэрбээр уул уурхайд түшиглэн хөгжиж буй орнуудад заналхийлдэг “Голланд өвчин”-ий талаар “нэвт шувт” мэдэх нэгэн. Тийм ч учраас Монголын эдийн засгийн чуулган дээр түүний энэ чиглэлээр хэлэх үг манай улс төр, эдийн засгийн салбарынханд тун сонирхолтой байх болов уу.

Вим Кок 1938 оны есдүгээр сарын 29-нд Голландын Бергамбахт тосгонд төрсөн. Тэрбээр Голланд улсын Ерөнхий сайдын албыг 1994 оны наймдугаар сарын 22-ноос 2002 оны долдугаар сарын 22 хүртэлх хугацаанд хашжээ. Кок бизнесийн чиглэлээр дипломатууд бэлтгэдэг байсан элит “Nyenrode” их сургуульд суралцан төгсөөд, худалдааны компанид ажиллаж байжээ. Үүний дараа 1961 онд Голландын Үйлдвэрчний эвлэлд ажилд орсон бөгөөд 1973-1982 онд тус эвлэлийн даргаар сонгогдон ажилласан. Энэ үед тэрбээр “Үйлдвэрчний эвлэлд би ширүүн ч бодитой бодлого явуулж ажиллана” гэж мэдэгдэж байжээ.

1989-1994 он хүртэл Дэд ерөнхий сайд, түүнчлэн Сангийн сайдаар ажиллаж байв. 2003 оны дөрөвдүгээр сард “Төрийн сайд” цолыг улсаасаа хүртсэн.

Кокийг Ерөнхий сайдын албыг хаших хугацаанд Голландын эдийн засаг хөгжин цэцэглэж, тус улсын эдийн засгийн хөгжлийн загварыг дэлхийд үлгэр жишээд тооцож байв. Эдүгээ тэрбээр ING групп, “Royal Dutch Shell”, TNT, KLM, Хяналтын зөвлөлийн гишүүн, мөн ардчиллыг дэмждэг “Club of Madrid”-ын тэргүүний албыг тус тус хашдаг юм.

ГОЛЛАНД ӨВЧНӨӨС
ГОЛЛАНД ГАЙХАМШИГ РУУ

Ажлын байр, ажлын байр, ажлын байр

Профессор Фрийсо Вийленганы бичсэн “Wim Kok: Ein pragmatischer Brueckenbauer” материалаас дараах зүйлийг ишлэв.


1980-аад оны эхэн үед Голландын эдийн засаг гүнзгий хямралд автсан байсан. Ажилгүйдлийн түвшин маш богино хугацаанд хоёр дахин өсч, 1982 онд хөдөлмөрийн насны хүн амын 13 хувь ажилгүйчүүдийн эгнээнд орсон байлаа. 1977 онд дөрвөн хувь байсан Голландын төсвийн алдагдал 1982 онд 10 хувьд хүрсэн байв. Энэ үеэс эхэлж Үйлдвэрчний эвлэлд орсон Кок ажлын байр бий болгохын төлөө зүтгэжээ. Арван жилийн дараа улс төрд орсон тэрбээр “Ажлын байр, ажлын байр, ажлын байр” хэмээх уриатай ажилласан. Кок олон улсад “polder model” нэрээр алдаршсан загварыг хэрэгжүүлсний үр дүнд 1980-аад оны “Голланд өвчин” ерээд оны “Голланд гайхамшиг” болж хувирсан гэдэг. Үүний ачаар эдийн засаг өсөж, ажилгүйдлийн түвшин буурч, төсвийн алдагдлаа хүртэл нөхсөн байна. Энэхүү загварыг хэрэгжүүлэхэд гол үүрэгтэй байдаг зүйл бол улс төрийн бодлого аж. Ерээд оны дунд үед Вим Кок дэлхийд хэрэгжүүлсэн загвараараа нэрд гарсан бөгөөд Билл Клинтон түүнд “Вим, Та анхных нь байсан шүү” гэж хэлж байсан удаатай. ■

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН

БИДЭНД БУСДАД ТААЛАГДАХ **ЮУ БАЙНА ВЭ**

Э.ЗОРИГТ

...Дэлхийн хэмжээнд өрсөлдөх брэнд бий болгох нь маш энгийн зүйлээс эхэлнэ. Бид юу хийхээс, хувийн хэвшил ямар зорилготой байгаагаас шалтгаална...



Фотог Зохиогч

Жил бүр болдог Монголын эдийн засгийн чуулганы талаар "Монголын эдийн засгийн форум 2013"-ын нарийн бичгийн дарга Б.Ган-Очиртой ярилцлаа.

-Эдийн засгийн чуулганаар хууль эрх зүй, инноваци, ногоон хөгжил гээд олон чухал сэдвээр ярилцдаг. Тэгвэл энэ удаагийн хурлын гол сэдэв юу байх вэ?

-Эдийн засгийн форум нэг талаас бодлого тодорхойлогч нөгөө талаас иргэний нийгмийн болон бизнесийн байгууллагын төлөөллүүд чуулж, жилдээ нэг удаа элэн далангүй ярилцах боломж юм. Энэ жил хэлбэрийн хувьд уламжлалаа хадгална. Харин агуулга талаасаа нэлээд өөр байх болно.

Монголын эдийн засгийн чуулган ирэх сарын 4,5-нд Төрийн ордонд болох бөгөөд энэ удаа үндэсний брэндийг хэрхэн бий болгох вэ гэдэг асуудлаар нухацтай ярилцах юм.

-Сүүлийн үед үндэсний брэндийг бий болгох талаар их ярьдаг болжээ. Тэгвэл Эдийн засгийн чуулганаар энэ талаар хэлэлцсэнээр ямар үр дүн гарна гэж Та бодож байна вэ?

-Үр дүнтэй ярилцаж чадвал дараа дараагийн үйл ажиллагаандаа тусгах олон чухал санал санаачилга гарах нь дамжиггүй. Тухайлбал, үндэсний брэндийг хэн бий болгох вэ гэдэг чухал асуудлыг ярилцах хэрэгтэй. Хувийн хэвшил үү эсвэл төр бий болгох уу. Аль эсвэл монголчууд хамтраад цоо шинэ брэнд бий болгох юм уу. Дараагийн нэг чухал асуудал бол Монголын юу брэнд болж чадах вэ гэдэг байна. Эдгээр асуултад хариулахын тулд бид хамгийн түрүүнд өөрт байгаа давуу талаа олж харах хэрэгтэй байх. Тухайлбал, Өвөлдөө -40,-50 хэм хүрдэг манайхаас яагаад хамгийн дулаахан хувцасыг дэлхий нийт худалдан авч болохгүй гэж. Малаар баян монголоос хамгийн сайхан амттай махыг дэлхийн зах зээлд гаргаж болохгүй гэх шалтаг бас л алга. За тэгээд ноос ноолуур, сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс шир гээд Монголд байгаа давуу талаа ашиглая л даа бүгдээрээ. Мэдээж брэндийг бий болгоход хүндрэлтэй асуудлууд гарна. Хамгийн наад зах нь ажиллах хүч, техник технологийн асуудал гээд хүндрэлтэй зүйл бишгүй бий. Гэхдээ ямар ч асуудлыг шийдэх боломж бололцоо нь өнөөдөр бүрдсэн. Бидэнд мөнгө байна уу байна. Цаашдаа ч уул уурхайн баялгаас их мөнгө орж ирнэ. Тиймээс тэр мөнгийг брэнд бий болгоход зарцуулах хэрэгтэй. Чуулганы үеэр олон талын төлөөлөл цугларах учир брэндийг бий болгоход тулгарч байгаа хүндрэлтэй

асуудлаа олон талаас нь ярилцаж, арга замаа тодорхойлох нь чухал. Ер нь эдийн засгийн форум гэдэг нь ард иргэд, төр, хувийн хэвшлийнхэн өөр хоорондоо чулуугаар байлдахаас урьдчилан сэргийлж, нүүр нүүрээ хараад ярилцах боломжийг бүрдүүлэх юм шүү дээ. Тиймээс үр дүн гаргахын тулд талууд идэвхтэй, илэн далангүй байх хэрэгтэй.

-Чуулганы үеэр бизнесийн орчин, өрсөлдөх чадварын асуудлаар салбар хуралдаан болно гэсэн. Энэ талаар тодруулахгүй юу?

-Үндэсний брэнд бий болгохын тулд бизнесийн орчин, өрсөлдөх чадварын тухай зайлшгүй ярих хэрэгтэй. Ний нуугүй хэлэхэд, өнөөдөр Монголын бизнесийн салбарт төрийн оролцоо их байна. Гэхдээ төрийн зохистой оролцоо байх зайлшгүй шаардлага бас бий. Хэрвээ төр хувийн хэвшлийнхнийг шахдаг, татварын орчноор дарамталдаг, улс төрийн ялгаварлан гадуурхал явуулдаг бол энэ нь төрийн буруу оролцоо. Тиймээс шударга бус оролцоог халах хэрэгтэй.

Монголын төр бизнесийн орчинд чөдөр болж байсан түүх бол байгаа. Гэхдээ бага багаар сайжирсаар л байна. Шинэчлэлийн Засгийн газар иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагааг ил тод болгох тал дээр анхаарч байгаа. Ер нь төрийн үйл ажиллагаа ил тод байх нь иргэдийн хяналтыг сайжруулдаг. Хэрвээ төр байх ёсгүй байрандаа байвал ард түмэн шүүмжилнэ шүү дээ. Иргэдээрээ хянуулсан төр шударга, зөв зохистой үйл ажиллагаагаа явуулдаг. Ер нь төрийн зохистой оролцоо гэдэг нь үүргээ нэр төртэй биелүүлэх гэсэн үг юм.

-Брэнд гэж ярихаар дотоодын хэрэгцээгээ хангаж чадахгүй байж гэж ирээд л шүүмжлэх хэсэг байдаг. Мөн брэнд бий болгох нь дотоодын хэрэглэгчдэд үнийн дарамт учруулна гэх нь ч бий. Эдгээр шүүмжлэл хэр үндэслэлтэй байдаг вэ?

-Асуудлыг аль талаас нь харах вэ гэдэг чухал. Зөв талаас нь хараад зорилгоо биелүүлэхийн төлөө л зүтгэх хэрэгтэй. Харин болохгүй бүтэхгүй



асуудал байгаа бол гарах гарцаа олох нь чухал. Түүнээс биш, бүтэхгүй гээд л болохгүй талаас нь яриад зүгээр суугаад байж таарахгүй.

Би дээр хэлсэн хэн брэндийг бий болгох вэ гэдэг чухал талаар. Хэрвээ төр дангаараа брэнд бий болгоно гээд зүтгэвэл олон хүндрэлтэй асуудал гарч магадгүй. Харин хувийн хэвшлээ дэмжээд тэднийг хөдөлгөвөл илүү үр дүнтэй. Учир нь, хувийн хэвшил өөрсдөө өрсөлдөх чадварыг бий болгож чаддаг. Тэдний дотор танил тал, авлига бараг байдаггүй шударга сектор. Тиймээс талууд чуулганы үеэр сайн ярилцаж нэгнээ ойлгох нь чухал. Хувийн хэвшил нь төрийн буруу оролцоог илэн далангүй ярь. Төр нь ч гэсэн буруу зүйлд гар дүрэхгүй байх, дүрж байсан бол болих хэрэгтэй. Цаашдаа хүчтэй нь даралдаг, хүч хүрэхгүй бол аргалдаг, авлига өгдөг буруу тогтолцоог халах цаг болсон. Тэгж чадвал бид дэлхийн хэмжээнд өрсөлдөх брэндийг бий болгож чадна. Зарим хүмүүс болохгүй бүтэхгүй талаас нь хэлдэг л дээ. Гэхдээ дэлхийн хэмжээнд өрсөлдөх брэнд бий болгох нь маш энгийн



зүйлээс эхэлнэ. Бид юу хийхээс, хувийн хэвшил ямар зорилготой байгаагаас шалтгаална. Өнөөдөр манай ямар ч хувийн хэвшлийн компани “Samsung”-тай өрсөлдөх гар утас, “Toyoto”-той эн зэрэгцэх машин үйлдвэрлэх талаар ярихгүй байгаа. Харин тэд маш энгийн зүйл ярьж байна. Хамгийн дулаахан оймс, хамгийн зөөлөн ноолуур, хамгийн амттай мах үйлдвэрлэе гэдэг. Энэ чинь л бидний давуу тал.

Улс үндэстэн бүр дахин давтагдашгүй өв соёлтой. Түүндээ тулгуурлаад л брэндийг бий болгох учиртай. Өнөөдөр бидэнд хаа ч байхгүй амттай мах байна. Гэхдээ эрүүл ахуй, олон улсын стандартын тал дээр учир дутагдалтай. Тэгвэл тэр дутагдлаа л бүгдээрээ арилгах хэрэгтэй. Тэгж чадвал Монгол брэндийг бий болгох хэцүү, харь холын юм биш. Брэнд гэдгийг үнэтэй хослол, цаг, машин мэтээр төсөөлдөг явцуу сэтгэлгээнээсээ салах цаг болсон. Харин бидэнд бусдад таалагдах юу байна вэ гэдгээ олж харах нь чухал.

-Монголын эдийн засгийн чуулганыг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн төлөөллүүд хүлээдэг. Одоогоор тэдэнд энэ талаар авсан мэдээлэл дутмаг байгаа болов уу. Тэр хүмүүст Та чуулгандаа идэвхтэй оролцохыг уриалж юу хэлэх вэ?

-Чуулганд оролцох зочдод урилга хүргүүлнэ. Мөн форумын үеэр үндэсний брэндийг ярилцахтай уялдуулан Монголын бүх үйлдвэр, аж ахуйн нэгжийн нэгдсэн томоохон үзэсгэлэнг зохион байгуулна. Тиймээс чуулганы үеэр нэг дор олон төрлийн мэдээллээр хангах бүрэн боломжтой юм. ■

ТӨСӨВ

ТӨРХӨМДӨӨ БУЦАХ **ТӨСӨВ**



Б.ЭНХ

...Төсвийн зарлагыг төлөвлөхдөө зардлын шинэ бөгөөд томоохон хоёр хүчин зүйлийг оруулж тооцоогүй байна. ...

Өнгөрсөн хугацаанд тодотгол хэмээх нэмэлт зарлагаар төсвийн нэрийг хугалж, өрийг нь өсгөж ирсэн.Тиймдээ ч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталж энэ оны эхнээс мөрдөхөөр болсон билээ. Тус хуулийн зорилго нь үрэлгэн төсвийг хазаарлаж, тогтворгүй бодлого тодорхойлогчдын томоогүй занг тогтоон барих.

“Төсөв-2013” Төсвийн тогтвортой байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэн анхны жилийн төсөв гэдгээрээ онцлог. Уг хуулийг Засгийн газар чандлан хэрэгжүүлж чадваас төсвийн алдагдал энэ онд хоёр хувиас хэтрэх ёсгүй.

Өнгөрсөн онд нэг хувьд барина хэмээн анхлан баталсан төсвийн нийт алдагдал жилийн эцсээр 7.7 хувь болжээ. Төсвийн бодлого 2012 онд хэт тэлсэн, мөчлөг дагасан шинжтэй байсныг Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкны мэргэжилтнүүд хэлж буй. Харин энэ онд хэрхэхийг хэрэгжүүлэгчдийн хэтийн бодлого, цаг хугацааны уялдаа харуулна гэдгийг ч мөн тэд хэлж байгаа. Дэлхийн банкны ахлах эдийн засагч Таехуюн Лий “ Ерөнхийдөө Монгол Улсын энэ оны төсөв хэт өөдрөг төсөөлөлтэй болсон ” гэж товчхон дүгнэв.

Оюутолгойн гэрээ өөрчлөгдөхгүй бол төсөв “хаашаа харна аа”?

Энэ жилийн төсөвт эдийн засгийг 18.5 хувиар тэлж, ДНБ-ий хэмжээг 17.6 их наяд төгрөгт хүрэхээр тооцоолжээ. Экспорт 78 хувиар огцом нэмэгдэж, уул уурхайн олборлолт 60 хувиар өссөнөөр дээрх өндөр өсөлтийг бүрдүүлэх аж. Мөн Монголбанкны инфляцийн 8.1 хувийн зорилт байгаа оновол тус өсөлтөд бодит нэмэр үзүүлнэ. Дэлхийн банкнаас өнгөрсөн оны сүүлчээр Монгол Улсын энэ жилийн төсвийн талаар гаргасан тайланд Хятад улсын эдийн засаг сэргэх хандлага ажиглагдаж байгаа ч тус улсын худалдааны гол түншүүд болох Европын холбоо, АНУ-ын эдийн засаг буурах эрсдэл байгаа нөхцөлд хэрхэх нь тодорхойгүй хэвээр байна. Ийм үед Монголын Засгийн газар эдийн засгийн өсөлтөө 18.5 хувь байхаар таамагласан нь хэтэрхий өөдрөг байх талтай гэж бичжээ. Өнгөрсөн оны сүүлээр манай эдийн засаг удааршсанаас үүдэн Дэлхийн банк 16.2 хувь, ОУВС 16.8

хувь болгон тус тус өсөлтийн таамгаа бууруулсан билээ.

Төсвийн нийт орлогыг өнгөрсөн оныхоос 28.9 хувиар өсгөж долоон тэрбум гаруй төгрөгт хүргэхээр төлөвлөжээ. Уул уурхайн экспорт нэмэгдэж, гадаад худалдааны тэнцэл сайжрах агаад үүнтэй зэрэгцэн уул уурхайн бус салбаруудын өсөлтийг харьцангуй өндөр байхаар тооцоолсон байна. Уул уурхайн нийт орлого төсвийн орлогын 24 хувийг бүрдүүлэхээр байгаа бол дийлэнх нь буюу 76 хувь нь бусад салбараас орж ирэх аж. Уул уурхайн орлого нь 2013 онд өмнөх оныхоос ойролцоогоор 62 хувиар өсөхөөр төлөвлөсөн нь Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулах мөн алт, нүүрсний экспорт нэмэгдэнэ гэж үзсэнтэй холбоотой гэдгийг Дэлхийн банкны тайланд бичжээ. Төсвийн орлогод 2009 оны Оюутолгойн гэрээнд дахин хэлэлцээр хийн нөөц ашигласны төлбөр таван хувь байсныг 20 хувь болгож, давхар татварын гэрээг мөн хөндсөнөөр орох нэмэлт орлого 445.8 тэрбум төгрөг гэж тооцжоо. Энэ нь анхны хөрөнгө оруулалтын гэрээний дагуу төлөх ёстой Оюутолгойн татварын дүнгээс бараг гурав дахин илүү мөнгө. “Оюутолгой” компани Засгийн газрын шахалтыг хүлээн авах эсэх нь тодорхойгүй байхад “цээжний хонжоо” хийж, дээрх мөнгийг төсөвтөө суулгачихаж.

Азийн хөгжлийн банкны эдийн засагч Л.Амар “Төсөвт энэ мэт тааварлахад бэрх орлогын эх үүсвэрийг багтаах нь зохисгүй” гэв. Дэлхийн банкны тайлангаас үзэхэд, хэлэлцээр хийх асуудлыг тойрсон тодорхойгүй байдал нь дээрх гэрээг мухардалд оруулж, Оюутолгой уурхайн үйлдвэрлэл хойшлогдон улмаар төсвийн орлого хүндрэх эрсдэл үүсгэж болзошгүй аж.

Төсвийн мөнгөний урсгал энэ жил хаашаа чиглэх вэ

Энэ жилийн төсөв өнгөрсөн оныхтой харьцуулахад нийт зарлага болон эргэн төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ нь 17.9 хувиар нэмэгдэж, 7.5 тэрбум шахам төгрөг байхаар тооцжээ. Өмнөх жилийн төсвийн зарлагад төрийн албаныхны 53 хувийн цалингийн нэмэгдэл ахиу жин дарж байсан бол энэ жилийн хувьд дотоодын хөрөнгө оруулалт 42.5 хувийн өсөлтөөр томоохон байр суурь эзлэх нь. Сүүлийн жилүүдэд шинэ хөрөнгө оруулалт болон засвар үйлчилгээний зардлын харьцаа алдагдаж буйг олон улсын байгууллагууд хэлсээр байгаа. Үүний тод жишээ нь энэ жилийн төсөв. Нийт засвар үйлчилгээний зардал энэ онд долоон хувиар буурахаар байгаа. Засвар үйлчилгээ, тордолгоог орхигдуулах нь төсвийн болон эдийн засгийн хувьд алдагдалтай бөгөөд одоогийн байгаа дэд бүтцийн ашиглалтын хугацааг багасгаж, ирээдүйд түүнийг шинэчлэх хугацааг ойртуулан өртгийг нэмэгдүүлснээр төсөвт илүү хүнд дарамт үүсгэнэ гэж Дэлхийн банкны мэргэжилтнүүд тайландаа тусгажээ. Хөрөнгө оруулалтын хэмжээ өсөн нэмэгдэж буй энэ үед засвар үйлчилгээнд зохих хэмжээний хөрөнгө хуваарилах нь одоогийн байгаа болон шинээр хийгдсэн хөрөнгө оруулалтын чанарыг баталгаажуулах, үр ашгийг нь хүртэхэд голлох үүрэгтэй.

Харин төсвийн зарлагыг төлөвлөхдөө зардлын шинэ бөгөөд томоохон хоёр хүчин зүйлийг оруулж тооцоогүй байна. Нийт 718 тэрбум төгрөгийн өртөг бүхий Үнэ тогтворжуулах хөтөлбөр болон Засгийн газрын 1.5 тэрбум ам.долларын бонд юм. Дэлхийн банкны тайлангаас үзэхэд эдгээр нь төсөвт ихээхэн сөрөг нөлөөтэй ч тэглээ гээд төсвөөс гадуурх санхүүжилтээр ашиглаж болохгүйг анхааруулжээ.

Хэдий Үнэ тогтворжуулах хөтөлбөр нь гурван жилийн хугацаатай ч энэ хүрээнд Төвбанкнаас гаргах ихэнх зээл нь энэ ондоо гарч дууссан байх талтай гэнэ. Хөтөлбөрийг эхний ээлжинд Төвбанк зээл олгож санхүүжүүлэх агаад зах зээлд ДНБ-ий дөрвөн хувьтай тэнцэх мөнгийг шинээр нийлүүлнэ. Үүнийг инфляцийг тогтоон барихад чиглэгдсэн хэрнээ үнэндээ инфляцийг улам өдөөсөн арга хэмжээ гэдгийг Дэлхийн банкны мэргэжилтнүүд хэлж байна. Тус хөтөлбөрт Монголбанкыг хэт татан оролцуулж, үүрэг ролийг нь хэлбийлгэж буй бөгөөд төсвөөс гадуурх санхүүжилт болгон ашиглах болзошгүй байдалд хөндлөнгийн мэргэжилтнүүд ихээхэн шүүмжлэлтэй хандаж байгаа.

Нөгөө талаас 2013 оны ДНБ-ий 11-12 хувьтай тэнцэх их хэмжээний зээл буюу 1.5 тэрбум ам.доллар нь төсөвт хүнд ачаа болохоор байгаа аж. Учир нь энэ оны төсөвт тус бондын зөвхөн хүүгийн төлбөрийг тусгажээ. Мэргэжилтнүүдийн зүгээс бондын энэ оны төсвийн алдагдалд хэр нөлөө үзүүлэх нь Засгийн газар бондын орлогыг хэрхэн захиран зарцуулахаас ихээхэн хамаарна гэж үзэж буй. Азийн хөгжлийн банкны ахлах эдийн засагч Яан Хансэн “Бондын мөнгийг Хөгжлийн банкаар дамжуулан орлого бий болгодоггүй төслүүд санхүүжүүлбэл, ирэх жилүүдийн төсөвт нөлөөлж эхэлнэ. Мөн энэ нь төсвийн зардлаас гадна, давхар нийт эрэлтэд нөлөөлж, эдийн засагт инфляцийн дарамт бий болгох юм” гэв.

Тэрбээр мөн хэлэхдээ “Төсвөөс гаднах зарлагыг төсөв дээр нэмж тооцвол алдагдал харьцангуй өндөр гарахаас гадна төсвийн бодлогын нөлөө нийт эрэлтийг илүү ихээр нэмэгдүүлнэ” гэж хэлсэн юм. Өмнөх жилүүдэд төсөвт удаа дараа тодотгол хийж ирсэн бол энэ жилийн хувьд тодорхой сувгуудаар төсвөөс гадуурх санхүүжилт хийн, зарлагад тусгалгүй “нүд хуурах” гэзд байна уу гэх хардлагыг энэ жилийн төсөв битүүхэндээ олны дунд төрүүлэх боллоо. Хэрэв Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулснаар нэмэгдэх орлого болон өнгөрсөн оны дутуу төвлөрсөн эрсдэл мөн бонд, Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн зарлагыг багтаваас төсвийн нийт алдагдал зургаан хувиас давж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хоёр хувийн хязгаарыг зөрчихөөр байгааг Дэлхийн банкны тайлан харуулжээ. Гэвч дээрх алдагдлын хэмжээ төсвийн нэмэлт зардлын төлөвлөлтийг төр хэрхэн хийхээс шалтгаалан хэлбэлзэж болох талтайг мэргэжилтнүүд хэлж байна.

Төсвийг төвхнүүлэх төрийн хууль хэрэгжих эсэх нь улсын бодлого тодорхойлогч, хэрэгжүүлэгчдээс ихээхэн хамааралтайг олон улсын байгууллагынхан хэлж байна. ■

2012 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүд

	Тэрбум төгрөг			ДНБ-д эзлэх хувь			2013 Төсөв (өөрчлөлт %)
	2011 гүйцэтгэл	2012 тодотгол	2013	2011 гүйц	2012 тод	2013	
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ	**4,468,198.0**	**5,631,686.9**	**7,258,092.4**	**40.3**	**34.9**	**41.1**	**28.9**
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	**4,227,178.1**	**5,530,336.9**	**7,088,333.7**	**38.1**	**34.3**	**40.2**	**28.2**
Татварын орлого	**3,668,307.8**	**4,925,603.9**	**6,461,531.6**	**33.1**	**30.5**	**36.6**	**31.2**
Орлогын татвар	833,738.9	950,859.7	1,261,481.6	7.5	8.2	5.9	32.7
ХАОАТ	232,257.3	292,182.2	397,727.5	2.1	1.8	2.3	36.1
ААНОАТ	545,631.1	658,677.5	863,754.0	4.9	4.1	4.9	31.1
Нийгмийн даатгалын шимтгэл	473,351.3	591,565.0	732,018.1	4.0	4.7	3.7	23.7
Борлуулалтын татвар ба НӨАТ	1,114,382.5	1,734,053.0	1,940,163.9	11.0	11.0	10.7	11.9
Онцгой татвар	293,967.0	376,367.5	595,227.5	3.0	2.9	2.3	58.2
Гадаад худалдааны татвар	337,422.6	565,955.9	575,299.6	3.5	3.3	3.5	1.7
Бусад татварууд	662,859.7	1,296,310.9	633,451.2	5.1	5.6	4.1	95.6
Нөөц ашигласны төлбөр	204,921.7	291,646.4	367,329.4	1.8	1.8	2.1	26.0
Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр	177,785.2	193,365.1	199,035.1	1.6	1.2	1.1	2.9
Татварын бус орлого	**545,366.5**	**602,915.0**	**625,986.5**	**4.9**	**3.7**	**3.5**	**3.8**
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	**4,997,040**	**6,312,220.3**	**7,444,625.0**	**45.1**	**39.1**	**42.2**	**17.9**
УРСГАЛ ЗАРДАЛ	**3,236,403**	**4,606,347.5**	**4,906,137.0**	**29.2**	**28.6**	**27.8**	**6.5**
Цалин хөлс	802,465	1,220,856.9	1,406,241.5	7.2	7.6	8.0	15.2
Бусад бараа үйлчилгээ худалдан авах	702,040	870,752.0	1,072,066.4	6.3	5.4	6.1	23.1
Татаас шилжүүлэг	**1,694,577**	**2,363,149.3**	**2,028,389.1**	**15.3**	**14.6**	**11.5**	**(14.2)**
Татаас	122,881	119,232.8	185,993.3	1.1	0.7	1.1	56.0
Шилжүүлэг	1,571,697	2,243,916.5	1,842,395.8	14.2	13.9	10.4	(17.9)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**1,280,920**	**1,719,710.4**	**2,488,859.6**	**11.6**	**10.7**	**14.1**	**44.7**
Дотоодын хөрөнгө оруулалт	1,020,970	1,408,993.0	2,008,220.0	9.2	8.7	11.4	42.5
Хөрөнгийн засвар	50,139	55,776.9	51,875.4	0.5	0.3	0.3	(7.0)
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ (%)	**(769,862)**	**(781,883.4)**	**(356,291.3)**	**(6.9)**	**(4.8)**	**(2.0)**	**(54.4)**
НИЙТ ТЭНЦЭЛ (%)	**(528,841.8)**	**(680,533.4)**	**(186,532.6)**	**(4.8)**	**(4.2)**	**(1.1)**	**(72.6)**
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	**241019.89**	**101350.00**	**169,758.7**	**2.2**	**0.6**	**1.0**	**67.5**

Эх сурвалж: Сангийн яам (2013 оны төсөв) Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо



НОГООН

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

НОГООН ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ

ҮНЭ ХАНШ

ОРОН СУУЦНЫ ҮНЭ ӨСӨХ ТӨЛӨВТЭЙ БАЙНА

Б.ҮҮРИЙНТУЯА

Өвлийн тэсгэм хүйтнийг угтан утааны асуудал түмний санааг түгшээдэг. Утааг бууруулахад дөхөм болох нэг алхам бол орон сууцжуулах гэлцдэг. Гэтэл “Орон сууцны үнэ өндөр байна” гэхээс өөр мэдээлэл үгүй иргэд цөөнгүй байгаагаас үүдэн “Mongolian Economy” сэтгүүл үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн ханш хэрхэн хэлбэлзэж буй талаар мэдээлэл хүргэх зорилгоор өнгөрсөн оны дөрөвдүгээр улирлын ханшийн судалгааг сонирхуулж байна.


“Мастер Пропертис” компани үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн тойм судалгааг Үндэсний статистикийн хороо болон Монголбанкны Ипотекийн зээлийн тайлан зэрэгт үндэслэн бэлтгэж, тоймлон гаргадаг билээ.

Улаанбаатар хотод нийт 170 барилгын төсөл хэрэгжиж байгаагийн 12 төслийн барилга ашиглалтад оржээ. Дээрх нийт төслийн дийлэнх буюу 64 хувийг Баянзүрх болон Хан-Уул дүүргэт барьсан бөгөөд үнийн интервалаар шинэ орон сууцны 63 хувь нь 1.5-2.5 сая төгрөгийн үнэтэй байна.


Шинэ орон сууцны үнийн судалгаа /сая.төгрөгөөр/

Улаанбаатар хотод хэрэгжиж буй төслүүдийн үнийн судалгаа (дүүрэг болон үнийн интервалын нэгтгэлээр)																
Үнийн интервал /мян.төг/	БЗД		ХУД		СБД		СХД		ЧД		БГД		НД		УБ	
	Байрны тоо	Дундаж үнэ /мян.төг/	Байрны тоо	Дундаж үнэ /мян.төг/	Байрны тоо	Дундаж үнэ /мян.төг/	Байрны тоо	Дундаж үнэ /мян.төг/	Байрны тоо	Дундаж үнэ /мян.төг/	Байрны тоо	Дундаж үнэ /мян.төг/	Байрны тоо	Дундаж үнэ /мян.төг/	Байрны тоо	Дундаж үнэ /мян.төг/
1.500 доош	16	1.380	2	1.500	0	-	13	1.322	0	-	3	1.267	1	1.500	35	1.360
1.501-2.00	33	1.882	33	2.025	11	1.900	4	1.803	6	2.020	19	1.752	1	2.250	107	1.913
2.501 дээш	5	3.415	20	3.208	2	3.500	0	-			0	-	1	3.067	28	3.261
Нийт	54	1.876	55	2.436	13	2.146	17	1.435	6	2.020	22	1.686	3	2.272	170	2.021

Хэрэгжиж буй төслийн эзлэх хувь /дүүргээр/



Хэрэгжиж буй төслийн эзлэх хувь /үнийн интервалаар/



Шинэ орон сууцны зах зээлийн дундаж үнэ

Өнгөрсөн оны арванхоёрдугаар сарын байдлаар нийслэлийн хэмжээнд шинэ орон сууцны ам метрийн дундаж үнэ хоёр сая орчим төгрөг байсан бөгөөд өмнөх сартай нь харьцуулахад 1.3 хувиар, 2011 оны хоёрдугаар сарын ханшаас 35 хувиар өссөн үзүүлэлт юм. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйл нь 12 барилгын төсөл бүрэн дуусч, 51 төсөл дуусах шатанд орсонтой холбоотой аж. Үлдээд буй 158 төслийн 100 нь энэ онд багтан дуусах юм. Үүний 32 нь эхний улиралд ашиглалтад орох тул захиалга эрчимтэй авч эхэлсэн нь ийнхүү үнийн өсөлтөд нөлөөлж байгаа аж.

Орон сууцны дундаж үнэ, ам.метр /мян.төг/

Дүүрэг	2011 оны 4-р улирал /мян.төг/	2012 оны 3-р улирал /мян.төг/	2012 оны 11 дүгээр сар /мян.төг/	2012 оны 4-р улирал /мян.төг/	Сарын өөрчлөлт /хувиар/	Улирлын өөрчлөлт хувиар /мян.төг/	Жилийн өөрчлөлт /хувиар/
БЗД	1327	1605,4	1841	1876	1.8%	14.42%	41.30%
ХУД	1746	2402,8	2422	2436	0.5%	1.30%	39.50%
СБД	1737	2022,9	2103	2146	2%	4%	23.50%
СХД	1070	1459,1	1416	1435	1.3	-1.60%	34.40%
ЧД	2122	2072,5	2244	2020	-11%	-2.50%	-4.80%
БГД	1304	1582,8	1611	1686	4%	6%	29.20%
Дундаж	1493	1866	1994	2021	1.30%	7.67%	35.30%

Өнгөрсөн оны дөрөвдүгээр улиралд шинэ орон сууцны ам метрийн дундаж үнэ хоёр сая орчим төгрөг байсан нь 2011 оны мөн үетэй харьцуулахад 530 орчим мянган төгрөөр нэмэгдсэн үзүүлэлт юм. Харин энэ үеийн жилийн дундаж өөрчлөлт 35.30 хувьтай гарсан нь 2011 оны хоёрдугаар сарынхтай харьцуулахад 2.8 хувиар буурсан үзүүлэлт гэнэ. Хүснэгтээс харахад орон сууцны ам метрийн үнийн сарын өөрчлөлтийг нийслэлийн дүүргээр ангилбал Чингэлтэйд эл үзүүлэлт 2.5 хувиар буурчээ. Харин Баянзүрх дүүрэг сарын хамгийн өндөр өөрчлөлттэй буюу 14.4 хувийн өсөлттэй гарчээ.

Хэрэгжиж буй төслүүдийн хүчин чадал, айлын тоогоор

Дүүрэг	Нийт төслийн тоо, ширхэг	Нийт айлын тоо, ширхэг	Нийт төсөлд эзлэх хувь	Төслийн нийт борлуулалт /тэрбум. төг/
БЗД	53	9604	33.5%	1068
ХУД	52	7020	32.9%	1833
СБД	13	1439	8.2%	207
СХД	15	3117	9.49%	189.8
ЧД	6	690	3.79%	96
БГД	16	2493	10.1%	192.2
НД	3	880	1.89%	126.8
Нийт	**158**	**25240**	**100%**	**3712.8**

Төслийн барилгуудын 33.5 хувь нь Баянзүрх дүүрэгт баригдаж байна


Одоогоор нийслэлд хэрэгжүүлж буй 158 төслийн хүчин чадлыг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 23 шинэ төсөл нэмэгдсэн, нийт айлын тоо 4974 өрхөөр өсч, 25240 болсон байна. Шинээр ашиглалтад орж буй орон сууцны борлуулалт 72 орчим хувьтай байгаа тухай “Мастер Пропертис” компанийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн судалгаанд дурджээ.

Банкуудын орон сууцны зээл олголт


Банк	Хугацаа	Зээлийн хүү /сарын/	Зээлийн хүү /жил/	Хэмжээ	Барьцаа хөрөнгө	Зээл төлөх чадвар	Тайлбар
ХХБ	15 жил	1.5-1.6%	19.20%	150 сая.төг	90% гүйцэтгэлтэй байр	50%	Зээлдэгчийн амь насны болон хөрөнгийн барьцаа
Голомт банк	15-20 жил	1.90-1.95%	20.40%	120 сая.төг	Шинэ орон сууц бол улсын комисс хүлээж авсан байх	40%	Барьцаа хөрөнгийн даатгал 0.12% амь насны даатгал 0.12%
ХААН банк	10 жил	2-2.1%	25.20%	100 сая.төг	Шинэ орон сууц бол улсын комисс хүлээж авсан байх	40%	Барьцаа хөрөнгийн даатгал 0.12% амь насны даатгал 0.12%
Улаанбаатар банк	15 жил	1.9-2.1%	25.20%	100 сая.төг	Худалдан авч буй орон сууц	40%	Түр барьцаа тавьж болно. Хамтран зээлдэгч орно
Хас банк	15 жил хүртэл	1.5-1.7%	20.40%	Үнийн дүнгийн 40%	Шинэ орон сууц бол улсын комисс хүлээж авсан байх	50%	Хамтран зээлдэгч байх шаардлагатай
Төрийн банк	15 жил	1.7%	20.50%	100 сая.төг	Шинэ орон сууц бол улсын комисс хүлээж авсан байх	50%	Барьцаа хөрөнгийн даатгал 0.13%, амь насны даатгал 0.13%
Чингис хаан банк	10-20 жил	Хорооны хурлаар тогтооно		Үнийн дүнгийн 70%	Худалдаж авч буй орон сууц	50%	Зээлдэгчийн амь насны болон барьцаа хөрөнгийн даатгал
Хадгаламж банк	10 жил	2.2-2.5%	30%	100 сая.төг	Худалдаж авч буй орон сууц	40%	Зээлдэгчийн амь насны болон барьцаа хөрөнгийн даатгал

Арилжааны банкуудын орон сууцны зээлийн нэрлэсэн хүү өнгөрсөн оны гуравдугаар улиралтай харьцуулахад ХААН болон “Голомт” банкны нэрлэсэн хүү 0.25-0.2 хувиар өссөн байна.

Банкуудын олгосон зээл /сая.төг/



Жигнэсэн дундаж хүү



Хуучин орон сууцны үнийн судалгаа /сая.төгрөгөөр/

ЧД		1 өрөө	2 өрөө	3 өрөө
	2011q4	52.33	69.89	92.22
	2012q4	53.7	82.0	106.3
	2012q4 / 2011q4	▲ 2.6%	▲ 17.3%	▲ 26.1%

СХД		1 өрөө	2 өрөө	3 өрөө
	2011q4	39.6	54.8	6.1.8
	2012q4	47.25	58.7	70.14
	2012q4 / 2011q4	▲ 19.3	▲ 7.2%	▲ 14%

СБД		1 өрөө	2 өрөө	3 өрөө
	2011q4	50	73	86
	2012q4	63	78.6	98.8
	2012q4 / 2011q4	▲ 26.0%	▲ 7%	▲ 10%

БЗД		1 өрөө	2 өрөө	3 өрөө
	2011q4	43	62	86.4
	2012q4	55.75	72.25	97
	2012q4 / 2011q4	▲ 29.6%	▲ 16.5%	▲ 12.2%

БГД		1 өрөө	2 өрөө	3 өрөө
	2011q4	47.37	71.49	75.89
	2012q4	56	75.8	102.18
	2012q4 / 2011q4	▲ 18.2%	▲ 6.03%	▲ 34.6%

ХУД		1 өрөө	2 өрөө	3 өрөө
	2011q4	41.78	62.66	72.17
	2012q4	57	68.7	102
	2012q4 / 2011q4	▲ 36.6%	▲ 9.61%	▲ 41.3%

q- IV улирал


Эх сурвалж: "Мастер Пропертис" ХХК

БОДЛОГЫН СУДАЛГАА

ОЙРЫН ХУГАЦААНД САНХҮҮГИЙН ХЯМРАЛ БОЛОХ УУ

Б.БАЯРТОГТОХ

...2007-2008 оны дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралыг урьдчилан таамаглаж чадаагүйгээс олон санхүүгийн байгууллага их хэмжээний алдагдал хүлээсэн. Хямралын дараа эдийн засаг, санхүүгийн онолуудад өөрчлөлт, шинэ хандлага гарч байна...



Монгол Улс 2008 оны санхүүгийн хямралаас сургамж авч чадсан уу. Айсуй хямралыг урьдчилан таамаглах боломж бий юу. Санхүүгийн хямралыг өдөөж буй хүчин зүйлийг хэрхэн номхотгож эдийн засгийн тогтвортой байдлаа хадгалж үлдэх вэ. Энэ бүхэнд гарц нээх боломж бидэнд үлдсэн үү. Тэгвэл хямралын эсрэг эрэл хайгуул хийх цаг хэдийнэ иржээ. СЭЗДС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимийн багш, бизнесийн удирдлагын мастер, докторант Б.Мөнхзаяагийн хийсэн "Санхүүгийн хямралын үе дэх арилжаан банкны эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох арга зүй" судалгааны товч дүгнэлтийг хүргэж байна.

2007-2008 оны дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралыг урьдчилан таамаглаж чадаагүйгээс олон санхүүгийн байгууллага их хэмжээний алдагдал хүлээсэн. Хямралын дараа эдийн засаг, санхүүгийн онолуудад өөрчлөлт, шинэ хандлага гарч байна. Өмнө нь хэрэглэж байсан хямралыг таамаглах арга зүй үнэн бодитой, хангалттай мэдээлэл өгч чадаагүй тул арга зүйг боловсронгуй болгох судалгааг хийж байсныг онцлон тэмдэглээе. Санхүүгийн хямралыг хэд хэдэн онолоор тайлбарладаг. Сүүлийн хямралыг Минскийн онолоор олон эрдэмтэн тайлбарлаж байна. Энэ нь "Санхүүгийн хямрал бодит эдийн засгийн /бизнес/ мөчлөгтэй давхцдаг буюу мөчлөгийн оройн цэгээс унаж эхлэхэд санхүүгийн хямрал болдог, санхүүгийн хямралын дараа эдийн засгийн хямрал эхэлдэг" гэсэн нийтлэг зүй тогтол юм. Тиймээс бизнесийн мөчлөгийн түрүүлэгч индикатор / ТИ/-ыг ашиглан санхүүгийн хямралыг урьдчилан таамаглах боломжтой юм.


ТИ гэж эдийн засгийн өөрчлөлтөөс түрүүлж өөрчлөгддөг үзүүлэлт бөгөөд хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд ихэвчлэн түрүүлэгч байдаг. Хөрөнгийн зах зээл ихэвчлэн эдийн засгийн уналтаас түрүүлж уналтад ордог, мөн сэргэхээс өмнө сэргэдэг онцлогтой.

Дээрх онолд тулгуурлан 2008 онд OECD-ээс "Нэгдсэн түрүүлэгч индикатор" /НТИ/ тооцох аргазүйг боловсруулж одоогийн байдлаар Австрали, Герман, Итали, Их Британи, Канад, БНСУ, Япон зэрэг 36 улс ашиглаж байна. Уг индикатор нь хямралыг богино хугацаанд таамаглах чадвартай буюу 6-9 сарын өмнө таамаглах боломжтой. Тиймээс уг мэдээллийг эдийн засгийн болон бизнесийн оновчтой шийдвэрт ашиглаж байна.

Манай улсын бизнесийн мөчлөг, ТИ-ыг тодорхойлох зорилгоор найман хэсгийн 37 индикаторын хувьд 2000 »

оны нэгдүгээр улирлаас 2012 оны хоёрдугаар улирал хүртэлх мэдээлэл ашиглан шинжилгээ хийлээ. Эндээс зээсийн үнэ, уул уурхай, олборлох үйлдвэрлэл, төвбанкны бодлогын хүү, иргэдийн зээл, хадгаламж, зээлийн хүү, зээлийн бодитоор үйлчилж буй хүү, мөнгөний нийлүүлэлт, гадаад валютын албан нөөц, ам.доллар, юанийн төгрөгтэй харьцах ханш, хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд ТИ болох нь тодорхойлогдсон. Эндээс үнэлгээнд ач холбогдолтой гарсан индикаторуудыг ашиглан нэгдсэн нэг индикаторыг боловсруулсан ба үүнд иргэдийн хэрэглээний зээл, зээлийн хүү, М2, топ 20 индекс, зээсийн үнэ, гадаад албан нөөц, ам.долларын ханш гэсэн долоон индикаторыг багтаж байна.

НТИ нь бизнесийн мөчлөгийг хоёроос гурван улирлын өмнө таамаглах боломжийг олгож байна. Өөрөөр хэлбэл, судалгааны дүнд ойрын хугацаанд хямрал болохгүй. Хэрэв НТИ оройн цэгээс буурч эхэлбэл санхүүгийн хямрал 2-3 улирлын дараа болохыг дохиолох юм.




Богино хугацаанд санхүүгийн хямрал болохгүй гэж дүгнэж буй хэдий ч хямрал үүсгэх зарим хүчин зүйлсээс манай орны хувьд анхаарал татсан зарим үзүүлэлтийг тодорхойлон, өөрийн дүгнэлтийг хийж байна. Эдгээр хүчин зүйлсийг бодлого боловсруулагчид анхааралдаа авч зохих зөв бодлогыг барьж чадвал хямрал болох хугацааг уртасгаж болох юм.

Үүнд:

1. Эрх зүйн орчин: 2008 онд баталсан Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийн хугацаа 2012 оны арваннэгдүгээр сард дууссан. Үүнтэй холбоотойгоор өнгөрсөн оны хагас жилээс хадгаламжийн хэмжээ буурч эхэлсэн. Учир нь хууль баталсан дөрвөн жилийн хугацаанд хадгаламжийн хэмжээ 3.5 дахин өссөн. Хадгаламжийн бууралтаас шалтгаалан арилжааны банкууд зээл олголтоо багасгаж байгаа нь борлуулалт буурах, ажилгүйдэл нэмэгдэх зэрэг олон сөрөг үр дагаваруудыг авчирна. Энэ оны нэгдүгээр сард Хадгаламжийн даатгалын тухай хууль баталж, хэрэгжиж эхэлсэн ч одоог хүртэл үр дүн тодорхой бус байгаагаас нь хадгаламжийн хэмжээ нэмэгдэхгүй байна гэж үзэж байна. Мөн энэ оноос 100 сая төгрөгөөс дээш төгрөгийн хадгаламжид татвар ногдуулах хууль хэрэгжиж эхэлсэн нь нэг томоохон шалтгаан болж буй. Банкны хадгаламжийн 60 гаруй хувь нь томоохон хадгаламжийн хөрөнгө байдаг тул татвараас зайлсхийх зорилгоор банкуудаас хадгаламжаа татах, тараах зэрэг үйлдэл хийж байгаагаас банкууд хүүгээр өрсөлдөж, энэ нь зээлийн хүү буурахгүй байх үндэслэл болж байна. Зээлийн хүү нэмэгдэх нь зээлдэгчийг зээлийн хүүгийн дарамтад оруулах ба зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлөх сул талтай.


2. Үнийн хөөс: Манай улсын эдийн засаг ойрын таван жилийн хугацаанд уул уурхайн салбарын өсөлттэй холбоотойгоор огцом өсөх талаар олон судлаач хэлж байна. Энэ их хэмжээний өсөлт нь эдийн засгийн хэт халалтыг бий болгож, үнийн хөөс үүсгэх гол нөхцөл болдог. Тухайлбал, Орон сууцны зээлийн өсөлт, барилгын материалын үнийн өсөлт, төрөөс олгох зургаан хувийн хүүтэй зээл, “100 мянган айлын орон сууц”, “40 мянган айлын орон сууц” зэрэг хөтөлбөрөөс шалтгаалан орон сууцны үнэ сүүлийн хоёр жилийн хугацаанд 1.8 дахин өссөн байна. Цаашид ч орон сууцны үнэ өснө гэсэн хүлээлттэй байна. Түүнчлэн орон сууцны үнэ өсвөл бусад дараагийн санхүүгийн хямрал үүсэх нэг шалтгаан болно. Сүүлийн 50 жилийн хугацаанд болсон санхүүгийн хямралуудыг авч үзвэл талаас илүү хувь нь орон сууцны үнэтэй холбоотой байжээ.

Орон сууцны ам метрийн үнэ /ам.доллар/




3. Төсвийн алдагдал: 2012 оны төсвийн зардал нь орлогоосоо давж, төсөв 1.07 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Засгийн газраас Чингис бондыг олон улсын зах зээлд борлуулсан нь гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээр татаж, манай улсад орж ирэх валютын урсгалыг нэмэгдүүлсэн. Богино хугацаатай уг бондын эргэн төлөлтийн хугацаа болоход валютын гарах урсгал нэмэгдэж, дотоодын зах зээлд валютын хомсдол үүсэх замаар ханшийн огцом өөрчлөлт гарч болзошгүй. Мөн төсвийн орлогын тодорхой хэсгийг бүрдүүлж буй гадаадын зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа нь санхүүгийн хямралын нэг шалтгаан болдог.

Төсвийн тэнцэл




4. Банкны салбарын хөшүүрэг: 2012 онд банкны салбарын активын хэмжээ 10.9 их наяд төгрөг буюу сүүлийн гурван жилийн хугацаанд 1.85 дахин өсчээ. Гэвч энэ өсөлт нь өөрийн оруулсан хөрөнгийн бус санхүүгийн хөшүүрэг (бусдад төлөх өр)-ийн өсөлттэй холбоотой байна. Дунджаар нийт хөрөнгийн 88 хувь нь хөшүүрэг, 12 хувь нь өөрийн хөрөнгө байдаг бол 2012 онд энэ харьцаа 92.8 хувь болж өөрчлөгдөжээ. Тиймээс хөшүүргийн өсөлтөө дагаад банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хэт их хөшүүрэг нь санхүүгийн хямралын бас нэгэн шалтгаан юм.




5. Иргэдийн зээлийн өсөлт: Банкуудын активын өсөлттэй холбоотой зээл олголт нэмэгдсэн. 2012 онд нийт зээл олголт 6.9 их наяд төгрөгт хүрчээ. Үүний 46 хувь нь иргэдийн зээл. Энэ нь өмнөх оноос 23 хувиар өссөн үзүүлэлт. Сүүлийн үед арилжааны банкууд бизнесийн бус иргэдийн зээлийг хэт их олгож байгаа нь хямрал үүсэх нэг шалтгаан болох магадлалтай. Иргэдийн зээлийн хэмжээ нэмэгдэх нь хэрэглээ буюу эрэлтийг нэмэгдүүлж, бараа, үйлчилгээний үнэ өсөх хүчин зүйл болно. Иргэдийн зээлийн дийлэнх буюу талаас илүү хувь нь орон сууцны зээл эзэлж байгаа нь орон сууцны зээлийн өсөлтөд нөлөөлж буй нэг хүчин зүйл болж буй. Сүүлийн томоохон хямралыг үүсгэгч гол хүчин зүйл нь моргейжийн зээлийн өсөлт байсан тул энэ байдал манайд дахин давтагдах нөхцөл үүсч болзошгүй.

Хөрөнгийн зах зээл



6. Хөрөнгийн зах зээл: Хөрөнгийн зах зээлийн төлөв байдал нь санхүүгийн хямралыг илэрхийлэх хэмжүүр болох ба өнгөрсөн оны жилийн эцсийн байдлаар топ 20 индекс өмнөх оноос 15 хувиар буюу 16839.1 төгрөг болтлоо буурчээ. Энэ нь нэг талаас арилжааны систем шинэчлэгдэж байгаатай холбоотой байж болох хэдий ч төрийн бодлого тодорхойгүйгээс зарим хөрөнгө оруулагчид хөрөнгөө татсантай холбоотой байж болох юм. Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих эрхзүйн зохицуулалтууд шаардлагатай байна.



7. Гадаад валютын албан нөөц: Манай улсын гадаад валютын албан нөөцийн хэмжээ 2009 онтой харьцуулахад хоёр дахин өссөн хэдий ч өнгөрсөн онд өсөлтийн хувь буурсан байна. Гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын зээлийн өсөлттэй холбоотой валютын нийлүүлэлт нэмэгдэж буй өнөө үед албан нөөцийн хэмжээг цаашид нэмэгдүүлэх шаардлагатай. Гадаадын орнуудаас авсан зээл, бондын төлбөр төлөгдөх үед их хэмжээний валют манай улсаас гадагшлах тул төгрөгийн ханшийг тогтвортой байлгах, хамгаалах механизм хэрэгтэй байгааг харуулж байна. ■

ҮЗЭЛ БОДОЛ

ҮНДЭСТЭН ДАМНАСАН КОРПОРАЦИУДЫН ӨСӨН НЭМЭГДЭЖ БУЙ БАЙР СУУРЬ



П.МЯГМАРДОРЖ /ХУИС-ийн ОУХ-ны тэнхимийн эрхлэгч/

1980-аад оны сүүлч ерээд оны эхэн үеэс үзэл суртлын хоёр систем бүхий хүйтэн дайн дуусгавар болж, олон улсын харилцаанд хоёр туйлт систем задран унаснаар дэлхийн улсуудын улс төр, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа эрчимжин, харилцан хамаарал улам бүр нэмэгдсэн. XXI зуун гарсаар олон улсын харилцаа болон дэлхийн бодлогыг даяаршил хэмээх хүчин зүйл тодорхойлох болсон ба “дэлхий хавтгайрах” үйл явц газар авсаар байна.

Олон улсын харилцаанд цэрэг, улс төрийн харилцаанаас илүүтэй эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа хүчтэй болсноор олон улсын харилцааны нөлөө бүхий оролцогч нь Үндэстэн дамнасан корпораци (ҮДК)-ууд болон хувирч Олон улсын харилцааг маш хурдацтай өөрчилж буй нийгмийн хүчин зүйл болох даяаршлын үйл явцад гол нөлөөлөгч нь мөн л Үндэстэн дамнасан корпорациуд болж байна.

Анхны үндэстэн дамнасан корпорациуд хэдийд үүссэн талаарх асуудал маргаантай байдаг ба зарим судлаач 1118 онд байгуулагдан 1135 оноос банкны үйл ажиллагаа явуулж эхэлсэн “Орден Тамплиер” -ыг анхных хэмээн үздэг бол олон судлаач 1600 оны арванхоёрдугаар сарын 31-нд Английн хатан хаан I Елизаветийн баталсан захирамжийн дагуу байгуулагдсан Британийн “Зүүн-Энэтхэгийн компани” мөн үүнээс хоёр жилийн дараа байгуулагдсан Голландын “Зүүн-Энэтхэгийн компани”-ийг жинхэнэ утгаараа анхны Үндэстэн дамнасан корпорациуд байсан гэж үздэг байна.

77-ын бүлгээс (G-77) санаачилсан “Хөгжингүй орнуудын олон улс дахь монополь үйл ажиллагааг хязгаарлах тухай” асуудлаар 1972 онд Нэгдсэн үндэсний байгууллагын хүрээнд хийгдсэн хэлэлцээрийн явцад Үндэстэн дамнасан корпораци хэмээх нэр томъёог анх хэрэглэж эхэлсэн бөгөөд тус байгууллагын тодорхойлсноор хоёр ба түүнээс дээш тооны улсад үйлдвэрлэл, үйлчилгээний салбар эзэмшиж, өөрийн үйл ажиллагаагаа явуулдаг, олон улсын худалдаа үйлчилгээ, бизнес нь түүний үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг болдог компанийг Үндэстэн дамнасан корпораци хэмээнэ гэжээ.

ОХУ-ын Эдийн засгийн толь бичигт “Хэд хэдэн улсад өөрийн салбаруудыг эзэмшдэг, тэдгээр салбараар дамжуулан гол үйл ажиллагаагаа явуулдаг компани, корпорацийг Үндэстэн дамнасан корпораци гэнэ” гэсэн бол Харвардын их сургуулийн судлаачдын үзсэнээр Үндэстэн дамнасан корпораци нь дараах шалгуурыг хангасан байх ёстой ажээ. Үүнд:

-Гадаадад зургаа ба түүнээс дээш охин компани эзэмшдэг байх;

-Хувьцаагаа олон улсад худалдаалдаг байхын зэрэгцээ үйл ажиллагаа явуулдаг бүхий л улсын хөрөнгийн бирж дээр хувьцааны борлуулалт нь нээлттэй байх;

-Компанийн дээд удирдах бүрэлдэхүүнд салбарууд нь байрладаг улсуудын (хүлээн авагч улс) төлөөлөл орсон байх;

-Олон улсын болон дэлхийн хэмжээнд сэтгэж чадахуйц удирдлагын бүтэцтэй байх;

-Өргөн хүрээнд эдийн засгийн үйл ажиллагааг явуулах боломжоор хангагдсан компанийн стратегийг үр дүнд хүргэх байгууллагын бүтэцтэй байх зэрэг болно.

Мөн нийт орлогын 25-30 хувийг гадаад дахь салбаруудаасаа олдог компанийг Үндэстэн дамнасан корпораци гэнэ хэмээх тодорхойлолтыг ОХУ-ын зарим »

судлаач хийсэн байдаг.

Үүний зэрэгцээ үндэстэн дамнасан байдлын тусгай индекс байдаг бөгөөд дараах томъёог ашиглан тооцоолдог байна.

I T = 1/3 (AI /A + RI /R + SI /S) x 100%

- I T-Үндэстэн дамнасан байдлын индекс, %;
- AI-Компанийн гадаад дахь активийн хэмжээ;
- A-Компанийн нийт активийн хэмжээ;
- RI-Компанийн гадаад салбараар дамжуулан хийж буй бараа, бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээний хэмжээ;
- R-Компанийн нийт бараа, бүтээгдэхүүний худалдаа, үйлчилгээний хэмжээ;
- SI-Компанийн гадаад дахь салбарын ажилтан ажиллагсадын тоо;
- S-Компанийн нийт ажилтан ажиллагсдын тоо;

Үндэстэн дамнасан корпорациудыг ангилахын хувьд судлаачид голчлон гурван бүлэгт хуваан үздэг байна. Үүнд:

-Хөндлөн нэгдэл бүхий ҮДК-янз бүрийн улсад байрлах нэг буюу ижил төрлийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, мөн нэг төрлийн үйлчилгээ явуулдаг салбаруудыг эзэмшдэг корпораци.

-Босоо нэгдэл бүхий ҮДК-тодорхой улсуудад байрлах бие биендээ өөрийн бүтээгдэхүүнийг нийлүүлдэг салбаруудыг эзэмшдэг корпораци.

-Салангид ҮДК-янз бүрийн улсад байрлах хөндлөн болон босоо нэгдэл холбоосгүй салбаруудыг эзэмшдэг корпораци.

1939 онд 300 орчим ҮДК үйл ажиллагаа явуулж байсан бол 1999 он гэхэд энэ тоо 200 дахин өсөж 508.2 мянган салбар бүхий 59.9 мянган ҮДК үйл ажиллагаагаа явуулах болсон байна. Харин 2004 оны байдлаар 690 мянган салбарыг эзэмшдэг 70 мянган Үндэстэн дамнасан корпораци (үүнээс толгой компанийн 73 хувь нь хөгжингүй орнуудад, салбар компанийн 65.2 хувь нь хөгжиж буй орнуудад байрладаг)дэлхий даяар үйл ажиллагаа явуулж байгаа нь энэхүү оролцогчийн тоо хэмжээ хамрах хүрээ ямар их болсныг нотолж байна.

Дэлхийн хамгийн том эдийн засгийн 51 нь Үндэстэн дамнасан корпораци, үлдэх 49 хувь нь улсууд байгаа бөгөөд Сахараас өмнөх Африкийн нийт улсын (Sub-Saharan Africa) ДНБ-ий хэмжээ АНУ-ын “Женерал моторс” болон “Форд”-ын ашиг орлогыг гүйцэж чадахгүй байна. Мөн Японы зургаан том тэргүүлэх компанийн (Мицубиши, Мицуи, Сумимото г.м) ашиг орлого нь Өмнөд Америкийн бүх улсын ДНБ-тэй дүйж байгаа ажээ.

АНУ-ын Бодлого судлалын хүрээлэнгийн Глобал эдийн засгийн төслийн захирал Сара Андерсоны судалгаанаас үзэхэд, ҮДК-иудын дэлхийн эдийн засагт эзлэх хувь жилээс жилд нэмэгдэж байгаа бөгөөд 1983 онд дэлхийн эдийн засгийн 25 хувийг ҮДК-иудын борлуулалтын орлого эзэлж байсан. Энэ тоо 1999 онд 27.5 хувь болж өсчээ.

Дэлхийн тэргүүлэх 200 корпорацийн 82 нь (нийт корпорацийн 41 хувь) АНУ-д бүртгэлтэй (толгой компани нь байрладаг) бол энэ үзүүлэлтээр 41 корпораци бүхий Япон улс хоёрт жагсдаг байна.

Дараах хүснэгтээс 2011 оны байдлаар АНУ-ын тэргүүлэх 25 компанийн борлуулалтын ашиг орлогыг зарим улсын ДНБ-тэй харьцуулсан судалгааг харж болно.

Дэлхийн худалдааны байгууллага, Дэлхийн Банк, Олон улсын валютын сангаас хийсэн судалгаа нь тодорхой улсуудын хоорондын худалдаа, бараа эргэлтийг голчлон авч үздэг боловч үнэн хэрэгтээ дэлхийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний 50 хувь, дэлхийн худалдааны 70 хувь нь Үндэстэн дамнасан корпорацид ногддог бөгөөд дэлхий дээр хийгдэж буй өндөр технологийн худалдааны 80 хувийг энэ төрлийн корпораци эрхэлж, хүнсний бүтээгдэхүүний 50 хувийг үйлдвэрлэж буй аж. Түүнчлэн нийт Үндэстэн дамнасан корпорациудын валютын нөөц нь бүх улсын Төвбанкинд хадгалагдаж буй валютын нөөцөөс даруй 5-6 дахин илүү байна.

Дүгнэлт

Иймхүү Үндэстэн дамнасан корпорациуд нь санхүүгийн боломжтой байдаг тул олон нийт ялангуяа улс төрийн бүлэглэлүүдэд маш ихээр нөлөөлж, улмаар улс гүрэн, бүс нутаг цаашлаад Олон улсын хэмжээнд өөрийн байр суурийг хүчтэй байлгаж чаддаг. Улмаар дэлхийн даяарших үйл явцыг улам бүр гүнзгийрүүлж байгаа явдал нь энэхүү оролцогчийг ирээдүйн Олон улсын хэмжээний нөлөө бүхий үндсэн оролцогч болгох гарцаагүй дүр зураг өнөөдөр бий болоод байна.

Иймд олон улсын харилцаа болон эдийн засгийн шинжлэх ухааны судалгааны чиглэлд (дэлхийн улс төрийн бодлогын цаашдын чиг хандлага, улс гүрнүүдийн гадаад бодлого, улсууд хоорондын харилцааны түүхэн уламжлал, өнөөгийн байдал зэргээс илүүтэй) дэлхийн эдийн засгийн цаашдын чиг хандлага, ялангуяа Үндэстэн дамнасан корпораци мөн Олон үндэстний корпорациудын (multinational corporation) түүх, тэдгээрийн бодлого буюу стратеги, үйл ажиллагааны зорилго, чиглэл зэрэгт анхаарлаа хандуулах зайлшгүй нөхцөл бий болжээ.

Нэн ялангуяа хөгжиж буй улсуудын эдийн засаг гадаад хүчин зүйлсээс, тэр дундаа Үндэстэн дамнасан корпорациудын хөрөнгө оруулалтаас маш их хамааралтай байгаа бөгөөд улс төрийн шийдвэр гаргалтад ҮДК-иуд шууд нөлөөдөг учир Монгол зэрэг бага буурай орны хувьд энэ талын судалгаа, шинжилгээний ажлыг эрчимтэй хийх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

ХОЙД ТУЙЛ УРСАЖ БАЙНА

Орчуулсан Б.ЗАЯА

...Грийнландын мөсөн бүрхүүл жилд ойролцоогоор 200 гигатонн мөсөө алдаж байна. Энэ нь тэрбум хүнийг ундлахад хангалттай ус юм...



The Economist сэтгүүлийн сэтгүүлч Жэймс Астил "Дэлхийн бусад газартай харьцуулахад Арктикт цаг уурын дулаарал хоёр дахин хурдацтай байна" гэжээ. Мөсний эзлэх талбай багасахын хэрээр ховор эрдэс бодис гаргаж авах, тэнгисийн шинэ зам нээх боломж бүрдэж байгаа ч сөрөг үр дагаварууд байсаар байна.

Та Грийнландын мөсөн бүрхүүл дээр зогсож үзвэл хүмүүс яагаад онгон байгальд дуртай байдгийн шалтгааныг ойлгох болно. Хаашаа ч харсан байгалийн өвөрмөц тогтоцтой мөс хараа булаана. Арктикийн цэнгэг агаар, уудам талд орших мөсөн сэрвэнгүүд, мөнгөлөг, номин цэнхэр өнгөтэй довцогууд зэрэг мөсөн бүтээлүүд таны сэтгэлийг догдлуулна.

Мөсөн бүрхүүл гэсээгүй хэвээр. Үлээх салхигүй, ямар нэгэн машин тэрэгний дуу чимээгүй, шувуудын жиргээ ч үгүй, ерөөсөө л аниргүй. Сайтар чагнавал хий хоосон дүнгэнэх чимээ л сонсогдоно.

Арктик нь дэлхий дээр хамгийн бага судлагдсан, онгон зэрлэгээрээ газар юм. Газар нутаг нь зах хязгаргүйн дээр тэнгис, гол мөрнүүдийн нэр бидэнд танил биш. Сибирийн Енисей, Лена, Миссиссипи, Ниль мөрнөөс ч их хэмжээний усаар далайг тэтгэдэг. Дэлхийн хамгийн том арал болох Грийнланд газар нутгаараа Германаас зургаа дахин том. Голдуу якутуудаас бүрдэх 57000 хүн ам эргийн дагуу тархан суурьшжээ. Арктикийг бүхэлд нь Арктикийн тойрог хэмээн тодорхойлдог ба хойд хэсгийн нарийн зурваст хуучнаар ЗХУ-ын харъяа байсан Мурманск, Магадан зэрэг хот байх бөгөөд тэнд дөрвөн сая орчим хүн амьдарна. Бусад буюу Сибирийн ихэнх, Аляск, Канадын хойд, Грийнланд болон хойд Скандиновт хүн бараг амьдардаггүй. Эдгээр бүсэд хүний хөлийн мөр хүрээгүй гэж болно.

Хурдтай урагшилж байна

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг өнгөөр ялган харуулсан доорх зурган дээр Арктикийг хүрэн улаанаар буджээ. 1951 оноос хойш энэ бүс нутгийн цаг уур дэлхийн дундажтай харьцуулахад хоёр дахин дулаарсан байна. Энэ хугацаанд дэлхийн дундаж температур 0.7 хувиар нэмэгдсэн бол Грийнландад 1.5 хувиар нэмэгджээ. Энэ байдал цаашид ч үргэлжлэх төлөвтэй аж. Хүлэмжийн хийн нөлөөгөөр дэлхийн цаг уур хоёр хувиар дулаарах нь тодорхой болоод байгаа ба энэ нь Хойд туйлд температур 3-6 хувиар нэмэгдэнэ гэсэн үг юм.

Арктикийн бараг бүх мөсөн гол нарийсч, багасаад байна. Цасны хэмжээ нь л гэхэд 1966 оныхтой харьцуулахад тав дахин багассаныг судлаачид нотолж байна. Гэвч хамгийн их аюулд өртөөд байгаа нь Арктикийн мөсөн далай юм. 1970, 1980,1990 онд мөсөн бүрхүүлийн хэмжээ хамгийн багадаа 10 жил тутамд найман хувиар багасч байсан бол 2007 онд далайн мөс хагарч, зун хамгийн багадаа 4.3 сая шоо метр мөс хайлсан байх жишээтэй. Энэ нь Канадын мэдэлд хамаарах Арктикийн 36000 арлын бүлгийг түүхэндээ анх удаа мөсгүй болгосон юм.

Эрдэмтэд үүнийг тайлбарлахыг оролдож байгаа бөгөөд 2007 онд бүхий л байгалийн үзэгдлүүд (дулаарал г.м) мөс хайлахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна. Гэвч 2011 оны

хувьд байгальд ямар ч гоц тохиолдол гараагүй атал мөс бараг дээрхтэй адил хэмжээгээр багасчээ.

Дулааралд нөлөөлж буй үндсэн шалтгааны талаар жинтэй таамаг алга. Арктик гэлтгүй дэлхийн хаа сайгүй дулаарал явагдаж байгаа нь чулуужсан түлшний шаталтаас үүссэн нүүрстөрөгчийн давхар ислийн нөлөөгөөр агаар мандал дахь хүлэмжийн хийн өсөлтийн үр дүн гэдэг. Агаар мандал нарны илчийг бага нэвтрүүлж байгаа учраас дулаарал явагдаж байгаа гэх физик нөлөөний таамгийг 1896 онд Шведийн эрдэмтэн Сванте Аррениус гаргаж байжээ. Гэвч дулаарал яагаад Арктикт бусад газраас илүү хурдацтай явагдаад байна вэ?

Албедо буюу цагаан өнгөний нөлөө

Хойд, Умардын агаарын солилцоо хурдацтай явагдаж буй нь дулаарлын нэг шалтгаан байж магадгүй гэнэ. Умардыг чиглэсэн салхи Европын хөө тортог, Азийн утаа зэрэг бохирдуулагчдыг зөөн авчирдаг нь цасанд дулааны нөлөө хүчтэй үзүүлдэг. Якутуудын хоол хүнсэндээ хэрэглэдэг цагаан халим, далайн морь болон цагаан баавгайн эд эс дэх мөнгөн усны хэмжээ сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа аж. Энэ нь Арктикийн онгон зэрлэг байдлаа алдаж буйн нэг шинж гэдгийг судлаачид тэмдэглэжээ.

Цас, мөсний оронд бараан газар, ус бий болж байгаа нь Арктикийн эрчимтэй дулаарлыг илчилнэ. Бараан гадаргуу илүү дулаан шингээдэг. Ингэснээр цас, мөс хайлж харин ус, газар нэмэгдэнэ. Албедо хэмээн нэршсэн цагаан өнгөний нөлөө нь ихэнх эрдэмтний төсөөлж байснаас хамаагүй эерэг үр дүн үзүүлдэг аж. Цаг уурын ихэнх төлөөр Арктикийн далайг бүрхсэн мөсөн бүрхүүл энэ зууны сүүлийн зун гэхэд бүрэн хайлна гэж таамагласан бол 2009 онд хэвлэгдсэн Геофизикийн судалгааны мэдээлэлд энэ үйл явдал 2037 онд тохионо гэжээ. Харин одоо зарим эрдэмтэн уг үзэгдэл тун удахгүй болно гэж байна.

Мөсний нөөц дундрахын хэрээр



Арктикийн эрэг идэгдэж байгаа бөгөөд Аляскын мөс жилд 14 метрээр хорогдож байна.

Мөсөн дээр тогтсон жижиг цөөрөм зэрэг амьтдын оромжны тоо улам л багасч байгаа аж. Арктикт амьдардаг маш ховор төрлийн зарим амьтны оромж үгүй болж, өмнөдийн худалдаачид тэдэн рүү хошуурах болсноор устаж үгүй болох аюул нүүрлэжээ. Цагаан баавгай зэрэг Арктикийн амьтад амьдрахын тулд тэмцэж байна. Тус бүс нутагт шинэ хар амар загас, Атлантикийн саламгай загас зэрэг загаснууд аялагчдын торыг дүүргэж байна. Арктикийн эдгээр өөрчлөлт тун удахгүй өргөн хэмжээнд яригдана хэмээн судлаачид сэтгэл зовнин ярьж байна.

Мөсөн далай хайллаа гээд далайн түвшинд нөлөөлөхгүй. Учир нь хөвөгч мөс нь өөрийн зайгаар далайн усанд шингэнэ. Харин мөсөн голуудын хувьд далайн түвшин нэмэгдэхэд өөрчлөлт ихээр мэдрэгдэнэ. Арктикийн мөс их хэмжээгээр хайлж байна. Грийнландын мөсөн бүрхүүл жилд ойролцоогоор 200 гигатонн мөсөө алдаж байна. Энэ нь тэрбум хүнийг ундлахад хангалттай ус юм. Арктикийн жижгэвтэр бүрхүүлүүд, мөсөн голууд мөн л мөсгүйдэж байна. Зарим мэргэжилтэн энэ зуунд далайн усны түвшин 59 см-ээр нэмэгдэнэ гэх урьдчилсан тооцоо гаргажээ.

Өөр нэг айдас байгаа нь Арктикийн хайлсан мөсний хүчтэй түрлэг бусад далай руу түрэх явдал юм. Өнгөрсөн 60000 жилийн хугацаанд ийм үйл явдал долоон удаа тохиолдож байжээ. Санаа зовоож байгаа бас нэг зүйл нь Арктикийн мөсөн цэвдэг хайлснаар их хэмжээний нүүрстөрөгчийн давхар исэл, метан ялгарах аюул юм. Ийм явдал 55 сая жилийн тэртээ тохиолдож байсан бөгөөд хэдхэн зууны дотор температур таван хэмээр дулаарч байсан аж. Ийм төрлийн эрсдэлүүдийг тодорхойлох аргагүй юм. Цас хайлалтын түвшин, мөсөн голын татралт зэрэг Арктикийн өөрчлөлтийн элементүүд өмнө нь тохиолдож байсан үзэгдэл ч хүний үйл ажиллагаанаас болсон анхны тохиолдол болохоор хэр хугацаанд,

ямар хурдтай үргэлжлэхийг таашгүй байна.

Хойд туйлын баялаг

Хойд туйл хайлах байдал үргэлжилбэл үгүйрэл хоосролд хүргэж болзошгүй. Хүн төрөлхтний нөлөө байгаа цагт Арктикийн нэг ч амьтан ашиг хүртэхгүй. Далайн мөс хайлж байгаа нь эскимочуудын соёлын мөхлийг харуулж байж болох юм. Сануулж хэлэхэд, одоо цасан гэрт амьдардаг хүн бараг үгүй болсон. Мөн их хэмжээний цас, мөс хайлснаар олон хүн баяжих боломжтой юм. Мөсөн цэвдэг гэссэнээр Арктикийн том хэмжээний газрууд газар тариалан эрхлэхэд тохиромжтой болно. Хавар эрт эхэлдэг болсноор ургац 25 хүртэл хувиар өснө. Грийнландчуудын одоогийн авдаг 100 тонн төмс ирээдүйд авах ургацын дэргэд өчүүхэн сонсогдоно. Олон төрлийн ашигтай түүхий эдийн хүртээмж нэмэгдэнэ. Арктик эрдэс, баялгийн томоохон нөөцтэй. Аляскт цайр, Канадад алт, Шведэд төмөр, Орост никель элбэг бөгөөд дахиад цаана нь олборлолт хийж болохуйц их хэмжээний газар бий.

Арктикт мөн газрын тос, түлш бий. Магадгүй маш их нөөц байгаа. Хайгуулын лицензүүд тус бүс нутагт буюу АНУ, Орос, Канад, Грийнланд, Норвегит олгогдож эхлээд байна. Өнгөрсөн оны дөрөвдүгээр сарын 18-нд “ExxonMobil” Оросын “Роснефть”-ийн 500 тэрбум ам.доллар хүртэлх хөрөнгө оруулалтыг задгай тэнгисийн нөөц, Оросын Арктикийн Кара тэнгисийн судалгааг хөгжүүлэхэд зарцуулахаар шийдвэрлэсэн.



Мөс хайлахын хэрээр Арктикийн ховор атьтад устаж үгүй болох аюул нүүрлээд байна

Арктит шинэ үйлдвэрүүд шууд бий болчихгүй. Хойд туйлын хахир хатуу нөхцөлд ажиллахад их хөрөнгө шаардлагатай. 24 цаг үргэлжлэх түнэр харанхуй, Арктикийн хүйтэн салхи салхи үйлдвэрлэл бизнес явуулахад амаргүй байх болно. Одоогийн хайгуул хийж буй компаниудын ихэнх нь ойрын арван жилийн хугацаанд нүүрстөрөгч ялгаруулах бүтээгдэхүүн боловсруулахгүй аж. Гэвч цаг нь болохоор боловсруулж л таарна. Олз нь их байх тул газрын тосны компаниуд болон Арктикийн Засгийн газар үүнээс хүртэх нь тодорхой.

“ExxonMobil-Rosneft”-ийн гэрээ зарлагдахаас өмнөхөн Оросын Ерөнхийлөгч Владимир Путин “Задгай тэнгисийн талбай, ялангуяа Арктик манай орны стратегийн нөөц болно” гэжээ.

XX зууны сүүлийн хагаст, Арктик нь Орос АНУ хоорондын хамгийн ойр маршрут байсны хувьд цөмийн дайны үед гол талбар болж байжээ. Харин одоо Арктикт эзэмшдэг газар нутгаараа хамгийн томд тооцогдох Орос, Канад хоёр улсын хооронд зөрчилдөөн гарах вий гэх болгоомжлол бусдад байна. Арктикт газар нутаг эзэмшдэг найман орны зарим нь цэрэг зэвсгийн хүчээ зузаатгаж буй. Норвеги цэргийн ангийн төвөө Арктикийн Рэйтан хот руу 2009 онд шилжүүлсэн. Орос мөс бутлагчуудаа шинэчилж эхэлсэн. Арктиктай холбоотой зөрчилдөөнөөс болгоомжилсон сэрэмжлүүлэг цаг уурын дулааралтай зэрэгцэн нэмэгдсээр.

Арктик бол “terra nullius” буюу хэний ч харъяалалд байдагүй улс биш юм. Антрактидаас ялгаатай нь олон улсын гэрээ хэлцэлд захирагддаг бөгөөд ихэнх газрынх нь хил хязгаарыг тогтоочихсон. Уг бүс нутагт зургаан томоохон газар нутгийн зөрчил байдгаас хамгийн том нь Америк Канадын баруун хойд зүгийн газрын асуудал юм. Гэхдээ энэ хоёр улс дайн хийхгүй. Арктикийн орнуудын ихэнх нь Натогийн гишүүн.

Арктикийг чиглэсэн шинэ худалдааны замыг дагаад сөрөг үр дагавар ирэх нь тодорхой. Сибирийн эргийн дагуух зүүн хойд зам буюу Оросууд болон далайчдын нэрлэснээр Хойд зүгийн тэнгисийн маршрутаар аялах нь баруун Европ, зүүн Азийн хооронд явах замыг бараг гурав дахин товчилж буй юм. Энэ чиглэлийн маршрут нь одоогоор жилийн дөрөв, таван сар нээлттэй байгаа аж. 2010 онд тус замаар дөрвөн усан онгоц зорчиж байсан бол өнгөрсөн жил хоёр чиглэлд газрын тос зөөгч онгоц, загас зөөвөрлөгч хөргөгчтэй онгоц, далайн аяллын онгоц гээд нийт 34 хөлөг онгоц аялжээ.

Азийн томоохон экспортлогчид болох Хятад, Япон, Өмнөд Солонгос зэрэг орон мөсөнд явагч хөлөг онгоцонд хөрөнгө оруулаад эхэлсэн буюу төлөвлөж буй аж. Хүргэлтийн үйл ажиллагаанд зориулсан далайн замыг хөгжүүлэх том төлөвлөгөөтэй Орос улсын хувьд энэ нь нэг сумаар хоёр туулай буудаж буй хэрэг юм. Ингэснээрээ Арктикийн нөөц баялгийг зах зээлд түргэн хугацаанд гаргах, нүүрстөрөгчид донтсон эдийн засгаа өөрчилж, олон хувилбартай болгох боломж юм. Үүнд эрсдэлтэй талууд бий. Дайн биш юмаа гэхэд зөрчилтэй байгаа улсуудын хооронд зохицуулалт хийх шаардлага гарч ирнэ. Орост ашигтай зүйл Египетэд ашиггүй байж болох шүү дээ. Өнгөрсөн жил Египет улс “Suez” суваг буюу баруун-зүүн чиглэлтэй сувгаас таван тэрбум ам.долларын ашиг олсон билээ. Гэхдээ хайлж буй Арктикийн байгаль орчны эрсдэл ба ирээдүйд ирэх эдийн засгийн асар их ашиг хоёрыг харьцуулж боломгүй. Далайн мөс хайлж байгаа нь газар хагалахтай адил хүний гараар хийгдэж буй үйл биш юм. Мөс хайлах нь өгөөжтэй байж болох ч асар их үнээр олдоно. Дахин давтагдашгүй экосистем, ховор зүйлийн амьтад цаг уурын өөрчлөлтийн нөлөөгөөр устаж үгүй болно. Шалтгаан нь дэлхийн бохирдол бөгөөд үүний дагуулах эрсдэл нь дэлхий дахиныг хамарна. Бөглүү, халдашгүй байхаа нэгэнт больсон Арктик тун удахгүй хүн төрөлхтний хүч чадлын илэрхийлэл болно. ■

ЗАХИРЛУУД

“БИ БУСДААС ИЛҮҮ АЖИЛЛАХ ЁСТОЙ”



Фотог Э.Зоригт

Д.БЭХЭЭ

“Mongolian Economy” сэтгүүл “Захирлууд” гэсэн шинэ булан нээлээ. Энэхүү буланд бизнес нь амжилттай яваа компаниудын захирлуудыг урьж оролцуулж, удирдах арга барил, бизнесийн туршлагаас нь хуваалцах зорилготой юм. Анхны зочноор BSB компанийн захирал Б.Жаргалсайханыг урилаа. Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих болсон ерээд онтой зэрэгцэн бизнесийн гараагаа эхэлж, өдгөө эрийн цээнд хүрсэн BSB компанийг бий болгосон түүний амжилтын нууц юу байсан бол. »

-BSB компани 20 нас хүрчээ. Та зах зээлийн шилжилтийн үед компаниа хөл дээр нь босгосон. Өнөөдрийн амжилтын нууц чухам юу байсан бэ?

-Нууц гэхээсээ илүү бид анхнаасаа компани байгуулах зорилгоо зөв тодорхойлсон юм болов уу гэж боддог. Түүнээс биш, амлаж, амлалтдаа хүрэх ёстой. Би ийм л зорилгыг өмнөө тавьсан.

Мөн гаднын өндөр хөгжилтэй орны бэлэн туршлагаас багагүй судалж, үйл ажиллагаандаа тусгасан. Гадаадын эрдэмтэн, мэргэжилтнүүдийн зохиол бүтээлийг их уншиж, ажилдаа нэвтрүүлсэн. Амжилтын нууц гэвэл хүнээ буюу сургууль төгсөгчдийг харахаар нэг л их будилсан хүмүүс байх юм. Ажилд орох гэж ирээд, гурав хоноод л “Өө энэ миний ажил биш байна” гээд л яваад өгөх жишээний. Манай компани их, дээд сургуулийн гуравдугаар дамжааны оюутнуудтай гэрээ хийж дэлгүүртээ ажиллуулдаг.

Компани өөрийн гэсэн



богино хугацаанд их мөнгө олоход шунаагүй. Тэгвэл компани гэдэг сонгодог утгаараа ямар байх ёстой вэ.Олон улсад компанийг зах зээлийн нийгэмд өөрөө өөрийгөө урт удаан хугацаанд авч явах хамт олны нэгдэл гэж ерөнхийд нь тодорхойлдог. Энэ л зарчмын дагуу ажилласан. Үүн дотроо компани маань бас өөрийн гэсэн зорилготой. Тэр нь хийж байгаа ажлаа бусдаас сайн хийх юм. Энэ нь тухайн компанийг урт удаан хугацаанд тогтвортой, амжилттай оршин тогтнох үндэс болдог. Олон жил оршин тогнохын тулд үйлчлүүлэгчиддээ хамгийн чанартай, сайн бүтээгдэхүүн боловсон хүчнээ хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй. Тухайлбал, бид гадаадад мэргэжил боловсрол дээшлүүлсэн ажилтандаа тодорхой нэмэгдэл өгөх замаар урамшуулдаг. Энэ нь түүний боловсролыг дэмжиж буй нэг арга юм. Мөн англи хэлтэй бол нэмэгдэлтэй ч гэдэг юм уу. Одоогоор манай компаниас “Оюутан хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн зорилго нь оюутнуудыг ажил дээр гараад төөрч будилалгүй ажлын байртай болоход нь туслах юм. Нөгөө талаар манай компани эртнээс боловсон хүчнээ бэлтгэж буй нэг хэлбэр. Одооны их, дээд тогтолцоотой хөгждөг. Үүнд хэд хэдэн чухал зүйл хамаарна. Мэдээж хамгийн чадварлаг боловсон хүчин байх учиртай. Дараагийн нэг чухал зүйл бол харилцагч байгууллагууд. Сайн түншгүй бол ер нь ямар ч бизнес хол явахгүй. Дараагийнх нь хэрэглэгчид. Хэрвээ хэрэглэгчгүй бол борлуулалт байхгүй. Борлуулалт байхгүй бол ашиггүй гэсэн үг. Мөн нийгмийн орчин, сэтгэхүй аливаа бизнест их нөлөөлдөг. Орчноо мэдэрч чадвал тухай тухайн үед нь арга хэмжээ аваад явж болдог. Бизнесийг амжилттай явуулах олон хүчин зүйл бий. Тэр бүгдийг л аль

болох харилцан уялдаатай явуулах хэрэгтэй. Аль нэгийг нь л алдвал бизнест алдагдал гараад эхэлдэг. Ер нь товчхондоо тухайн компани амжилттай үйл ажиллагаа явуулна гэдэг нь асар том шинжлэх ухаан юм.

-Ерээд оны үед компаниа анх байгуулчихаад ирээдүйд тухайлбал, 2013 он гэхэд ийм амжилтад хүрнэ гэдэг төсөөлөл байсан уу?

-Миний хувьд 1993 онд олон улсын Мастрехтын худалдааны дээд сургуулийг дүүргэсэн. Тэгэхээр өөрийгөө будилж яваагүй гэж боддог. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр анхнаасаа л компани гэж юу байдгийг заалгаж байсан учраас тэр хэмжээндээ ажлынхаа гарааг зөв эхлүүлсэн болов уу. Гэхдээ бүх зүйл дардан байгаагүй. Манай улс зах зээлийн эдийн засагт шилжсэн гэх боловч бүх зүйл нь социализмаараа л байсан үе шүү дээ. Тиймээс олон хүндрэлтэй тулгардаг байсан. Зарим нь бүүр зах зээлийн эдийн засаг гэх ойлголтоосоо шал өөр тийшээ явж байсан гэхэд хилсдэхгүй. Харин компани бол өөрөө зах зээлийн эдийн засгийн сонгодог бүтээлийн нэг. Гэтэл социализмын сэтгэлгээтэй нийгэмд компани бий болгоно гэдэг амаргүй байсан. Хүмүүс дэмждэггүй, ойлгодоггүй л байлаа. Өнөөдөр ч гэсэн зарим нь компанийг сонгодог утгаар нь ойлгохгүй байдал ажиглагддаг. Зөвхөн ашиг л гэж хараад байдаг.

-Одоо болтол санаанаас гардаггүй бэрхшээлтэй зүйл юу байсан бэ. Тэр хүндрэлийг хэрхэн даван туулж байсан бол.

-Ер нь бизнесмэн хүн аливаа бэрхшээлийг даван туулах ёстой гэж би хувьдаа ойлгодог. Тэр утгаараа саад байвал даваад л гарах хэрэгтэй. Эргээд дурсахад хамгийн хэцүү даваа бол 1990-ээд оных бус 2008-2009 оны эдийн засгийн хямрал л байсан санагддаг юм.

-Яагаад?

-Хямрал гэдэг бол асар том сорилт юм л даа. Энэ сорилтод бүдрэхгүй тэсч үлдэх гэж нэлээд юм болно. Дэлхий нийтийг хамарсан тэр том сорилтод олон улсын томоохон бизнесийн байгууллагууд хаалгаа барьсныг монголчууд мэдэж байгаа. Ийм л үед бид тэсч үлдэх шаардлагатай нүүр тулсан. Тухайн үед зөв менежмент явуулсны үндсэн дээр өнөөдөр бид үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна. Тухайн үед валютын ханш огцом унаж төгрөгийн ханш ч шалдаа буусан шүү дээ. Энэ үед бидний нэг ам.доллараар борлуулах ёстой байсан бүтээгдэхүүн ердөө 60-хан цент болж байлаа. Иймээс гаднын бэлтгэн нийлүүлэгчдийн өмнө асар их өр бий болгосон гэсэн үг. Товчхондоо авсан үнээсээ хэт доогуур үнээр бараа бүтээгдэхүүнээ худалдаж байсан. Харин тухайн үеийн Монголын эдийн засгийн хямрал гадаад хүчин зүйлээс бус биднээс өөрсдөөс болсон гэж би үздэг. Дэлхий нийт хямарсан уу хямарсан. Манайд нөлөөлсөн үү нөлөөлсөн. Гэхдээ манай төр, засгийн буруу бодлого хамгийн их нөлөө үзүүлсэн нь үнэн. Тиймээс өнөөдрийн энэ хямрал ч юм шиг зогсонги байдал ч юм шиг дэлхийн эдийн засгийн нөхцөл байдалд хаа хаанаа харьцангуй туршлагатай болсон байна, төр ч, бид ч.

-Сүүлийн үед электрон бараа, тавилгын салбарт өрсөлдөөн улам ширүүсч байна. Нэг үеэ бодвол жижиг, том олон компани гарч иржээ. Тэгвэл танай компани өрсөлдөгчөө хэрхэн үнэлж дүгнэдэг вэ?

-Энэ бол тухайн компанийн стратегитай шууд холбоотой асуудал. Компани бол урт хугацаанд тогтвортой байх ёстой талаар хэлсэн. Богино хугацаанд ашиг олох амархан. Харин урт хугацаанд ашигтай байхад маш нарийн төлөвлөгөө шаарддаг. Өнөөдрийн байдлаар манайх цахилгаан бараа болон албан тасалгааны тавилгын борлуулалтын салбартаа тэргүүлэгч гэдэг нь маргаангүй үнэн. Бусад өрсөлдөгчид маань хүчтэй байна. Ер нь өрсөлдөөний олон арга бий. Тухайлбал, халз өрсөлдөх, өрсөлдөөнөөс зайлсхийж өрсөлдөх гэдэг ч юм уу. Ер нь заавал өрсөлдөөд байх ч албагүй. Хамгийн чухал нь өмнөө тавьсан зорилтдоо шударгаар, амжилттай л хүрэх ёстой. Өрсөлдөгчид олширч байгаа үед зайлшгүй өрсөлдөх хэрэг гарвал давуу талаа ашиглах хэрэгтэй. Гэхдээ өрсөлдөөний нэг гол зарчим бол чи өөрийн гэсэн худалдан авагч, үйлчлүүлэгчтэй л болох нь юу юунаас чухал. Шинээр байгуулагдаж байгаа компанийн нэг алдаатай тал байдаг. Тэр нь зах зээлд хямд үнээр танигдахыг зорьдог. Тэгвэл дандаа бусдаас хямд байж чадах уу гэдэг том асуудал гарч ирнэ. Та нараас хямдхан үнэ хэн нэгэн санал болговол хэрэглэгчид тийшээ л явна шүү дээ. Тиймээс тэд бол танай итгэлтэй үйлчлүүлэгчид биш. Хямд үнэ бол урт хугацааны амжилт авчирдаг зүйл биш. Харин яаж өөрийн гэсэн хэрэглэгчидтэй болох вэ гэсэн асуудалд анхаарлаа хандуулах нь л хамгийн чухал юм.

-Танай компанийн хувьд үйлчлүүлэгчдийнхээ сэтгэл ханамжийн талаар хэр судалдаг бол. Үйлчлүүлэгчээ хэр мэдэрдэг вэ?

-Заавал тусгай том баг гаргаад л судлаад байхдаа биш. Тухайн салбартаа үйл ажиллагаа тогтмол явуулж байгаа л бол үйлчлүүлэгчидээ аяндаа мэдрээд эхэлдэг. Үнэхээр юу юугаа ч мэдэхгүй байвал судлах шаардлагатай л даа. Манай компанийн хувьд тухайн салбарт 20 гаруй жил ажиллаж байгаагийн хувьд үйлчлүүлэгчдээ мэдэрдэг болчихсон. Туршлагатай эмч өвчтнийхөө царайг хараад л мэддэг шиг гэх үү дээ. Өдөр тутам энэ ажлыг хийж байгаагийн хувьд заавал том жижиг судалгаа хийх хэрэггүй болтлоо тэдний сэтгэл ханамжийг мэдэрдэг болсон байна.

-BSB цаашдаа зах зээлээ өргөжүүлэхийн тулд ямар стратеги боловсруулж байгаа талаараа хуваалцаж болох уу?

-Бидний нэг онцлог гэвэл тал тал тийшээ савчаад байдаггүй. Гэхдээ манай орны зах зээл жижиг учраас нэг бизнес богинохон хугацаанд ханачихдаг. Тиймээс ихэнх компани шинэ бизнес эхлүүлдэг. Манай хувьд ийм асуудал тулгарсан ч одоогийн бизнестэйгээ аль болох уялдаатай байхыг эрмэлздэг. Тиймээс одоогийн бизнесээ л улам төгөлдөржүүлэх тал дээр анхаарч ажиллана. Хоёр, гурван жилийн өмнөөс бид гэрийн мебель тавилгын бизнест орсон. Мөн үйл ажиллагаагаа өргөтгөх үүднээс Банк бус санхүүгийн байгууллага байгуулсан. Энэ нь BSB-гээс бараа зээлээр авъя гэвэл аль нэг банкинд

хандах биш, шууд л нэг дороос хүссэн бараагаа зээлээр авах боломжийг үйлчлүүлэгчиддээ нээж өгсөн хэрэг юм. Энэ нь нэг талаар үйлчлүүлэгчдийнхээ цагийг хэмнэх, нөгөө талаар бидэнд ч бас ашигтай. Энэ утгаар бид гэнэт уул уурхай эсвэл хүнсний үйлдвэрлэлд хөл тавихгүй. Яагаад гэвэл тэр салбарт биднээс илүү чадварлаг нь аль хэдийнэ хөлөө олчихсон байгаа шүү дээ.

Манай компаниудын хөгжил гаднын өндөр хөгжилтэй орны компанийн хөгжилд хүрэх яагаа ч үгүй байна. Ердөө л эхлэл төдий явж байна гэж хэлж болно. Нэг л жишээ хэлэхэд, гаднын компаниуд өндөр нэр хүндтэй байдаг. Гэтэл монгол компани гэхээр яаж хүлээж авдаг билээ. Яагаад гэвэл манайхан адаглаад татвараас зайлсхийдэг.

-Нийгмийн хариуцлагаа хэрхэн хэрэгжүүлдэг вэ?

-Нийгмийн хариуцлага гэдэг бол тухайн компанийн үйл ажиллагаа, хүлээх үүрэгтэй холбоотой асуудал. Хамгийн наад зах нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд татвараа 100 хувь төлөх хэрэгтэй. Нуун дарагдуулах ч юм уу тийм асуудал байж болохгүй. Бидний өгч байгаа татвар нийгэмд баялаг бүтээнэ шүү дээ. Татвараас зайлсхийдэг бол компани биш. Өнөөдөр манайд татвараас зайлсхийдэг компани олон байгаа бөгөөд шамшигдуулсан мөнгөөрөө ашиг олох гэдэг хүмүүс цөөнгүй байх шиг. Энэ бол увайгүй үйлдэл. Татвараас зайлсхийж байгаа хүний хүүхэд сургуульд явдаг, багш нар нь таны өгсөн татвараар цалинждаг гэдгийг ойлгох л хэрэгтэй. Та татвараа үнэн зөв төлөөд байвал багш нарын цалин нэмэгдэнэ. Тэр хэмжээгээр таны хүүхдийн олж авах боловсрол дээшилнэ. Энэ мэт нийгмийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлснийхээ дараа бусад нийгэмд тустай үйл хэрэгт хувь нэмрээ оруулах нь зүйн хэрэг.

-Манай зарим компани гадаад, дотоодын уралдаан тэмцээнийг ивээн тэтгэснийгээ нийгмийн хариуцлага гэх мэтээр сурталчлах явдал байдаг. Монголын компаниудын хөгжил хаашаа явж байна вэ?

-Манай компаниудын хөгжил гаднын өндөр хөгжилтэй орны компанийн хөгжилд хүрэх яагаа ч үгүй байна. Ердөө л эхлэл төдий явж байна гэж хэлж болно. Нэг л жишээ хэлэхэд, гаднын компаниуд өндөр нэр хүндтэй байдаг. Гэтэл монгол компани гэхээр яаж хүлээж авдаг билээ. Яагаад гэвэл манайхан адаглаад татвараас зайлсхийдэг. Энэ нь нэг талаар манай компаниуд бусдын төлөө биш зөвхөн өөрийн ашгийн төлөө ажиллаад байгаа хэрэг юм. Өөрийн ашгийн төлөө буруу зүйлийг хүртэл хийж байна. Өнөөдөр тендерт яллаа л гэнэ. Яаж ялсан нь тодорхой л байдаг. Ер нь хүний төлөө байж чадахгүй бол хэрэглэгчид чиний төлөө байхгүй дээ.

-Хялбар аргаар бизнес хийхийг сонирхогчид олшроод байх шиг.

-Бизнес гэх нь ч хаашаа юм бэ. Зүгээр л хялбар аргаар мөнгө олохыг хүсэгчид гэвэл таарна тэднийг. Зүгээр хялбар арга байвал бас нэг өөр хэрэг. Гэтэл тэр нь хууль бус үйлдэл байх нь олонтаа.

-Тэгвэл гаднын өндөр хөгжилтэй орны туршлага, арга аргачлал чухам ямар байдаг вэ?

-Дээхэн үед манай компанид зөвлөхөөр ирсэн нэг Финлянд хүний хэлсэн үг санаанаас гардаггүй юм. Тэр нь “Мөнгө олох маш олон арга бий. Тиймээс тэр олон аргаас заавал болохгүй бүтэхгүйг нь сонгох хэрэггүй” гэсэн юм. Нээрээ үнэн үг шүү. Бид тэр хүний үгийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгохыг зорьдог.

-Өнөөдрийн энэ буруу сэтгэлгээ манай төр, засагтай холбоотой гэж Та үздэг үү?

-Компани л гэж яриад байгаа болохоос манай улс төр, нийгэм тэр чигээрээ буруу сэтгэлгээ рүү хальтирчихсан. Компани бол нийгмийн л нэг хэсэг.

-Энэ сэтгэлгээний гажуудлаас хэрхэн гарах талаар Та юу гэж бодож байна вэ?

-Бага багаар сайжирч л байгаа. Ер нь хараад байхад чиг хандлага бол зөв тийшээ харчихлаа гэж хэлж болох юм. Би нам бус хүн. Гэхдээ өнгөрсөн оны сонгуулийг харахад л нийгмийн сэтгэлгээ өөрчлөгдсөн нь харагдлаа. Олон жил нэг намыг л сонгодог байсан бол өөр нам яллаа. Засгийн эрхэнд намууд ээлжилж гараад байвал шархаа нөхөх гэж биш, ажлаа хийж дараагийн сонгуульд ялахын төлөө шаргуу хөдөлмөрлөх байх. Тэгэхгүй дахин дахин сонгогдоод байвал ашгийн төлөө улайрагсад олширдог бололтой.

-Шинэ Засгийн газрын хувийн хэвшлийг дэмжих бодлогын талаар Та юу гэж бодож байна вэ. Одоогоор мэдрэгдсэн зүйл байна уу?

-Яг тийм гээд хэлэх дорвитой мэдрэгдсэн зүйл алга. Харин нэг шүүмжлэл хэлэхэд популист хандлагаас холдож чадахгүй байна уу даа гэж санагддаг. Мөн ард түмэнд таалагдах гэж хэтэрхий хичээгээд байх шиг. Хамгийн зөв шийдвэр гаргаж, зарчимч шударга байх хэрэгтэй

-Та Монголын амжилттай яваа бусад захирлуудаас юугаараа ялгаатай вэ?

-Ёстой хэцүү асуулт байна. Тэрийг би биш та нар л хэлнэ.

-Олон л зүйл байна шүү дээ. Удирдах арга барил. Ажилдаа бариmталдаг зарчим ч гэх юм уу?

-Миний нэг том зарчим байдаг. Тэр нь ажилтнууддаа үлгэр дуурайлал болохуйц ажиллахыг хичээдэг. Ер нь даргаасаа ажилчид нь үлгэр дуурайлал авдаг шүү дээ. Тэр утгаараа би бусдаас илүү ажиллах ёстой. Тэр хэмжээгээрээ илүү үр дүн гаргах учиртай. Хамгийн зөв шийдвэр гаргаж, зарчимч шударга байх хэрэгтэй. Түүнээс биш, өөрөө



ажлаасаа хоцорчихоод бусдад шаардлага тавиад байвал хэн хүлээж авах вэ. Гэхдээ энэ бол миний л зарчим. Дээрээс нь би шинжлэх ухаанд итгэдэг. Түүнээс биш, сургаар үнэлэлт дүгнэлт гаргадаггүй.Баримт нотолгоогүй зүйлд ач холбогдол өгдөггүй.

-Монгол Улсад стандарт алга гэдэгтэй санал нийлэх үү?

-Монголчуудын шаардлага сул байна. Гүйцэтгэлийн стандарт, чанарын тал дээр муу дүн авна. Өнөөдөр бидний онц дүнтэй өглөө гэсэн ажил гаднын аль нэг оронд очоод муугийн муу дүн авах жишээтэй. Адаглаад авто замын стандартаа хар. За тэгээд эмчилгээний, сурлагын, барилгын гээд бүх л стандарт нь доогуур байна. Ний нуугүй хэлэхэд зарим газар стандарт ч алга. Мэргэжлийн тухайд бүр ямар ч стандартгүй болсон. Бараг л хүн бүр байшин барьж байна. Бүгд барилгын сургууль төгсөөгүй байлтай. Миний өмнө нь таньдаг байсан бизнесмэн барилгачин болчихсон байна. Уг нь худалдааны л мэргэжилтэй хүн. Монголчууд ер нь бүгдийг чадна гэж боддог. Гэтэл яг стандарт түвшинд нь аваад үзвэл юу ч хийж чадахгүй байгаад л хамаг учир бий.

-Аливаа байгууллагын амжилт бол хүн. Та боловсон хүчнээ сонгож авах тал дээр хэрхэн анхаарч ажилладаг вэ?

-Хамгийн чухал асуудал л даа. Харамсалтай нь манай улсад хүний нөөцийн менежер гэдэг шинжлэх ухаан хөгжөөгүй байна. Урьд нь ч байгаагүй. Түүнээсээ болоод энэ тал дээр нэлээд алдаа гаргадаг. Нэг ажилтан авчихдаг гэтэл нөгөөх нь үүрэг болгосон ажлаа хийдэггүй. Ямар ч санаачилгагүй. Гаднын мэдлэг чадвартай багш нарыг энэ салбарт оруулж ирэх нь чухал гэж би боддог. Миний хувьд хүний нөөцийн чиглэлээр гаднын томоохон эрдэмтдийн гаргасан номыг ажилтнууддаа уншуулах, төрөл бүрийн сургалтад хамруулж чадавхижуулахад анхаардаг. Гэхдээ энэ нь тийм ч төгс төгөлдөр байж чаддаг уу гэвэл тийм гэж хэлж чадахгүй. Гэхдээ юу ч хийхгүй байснаас л дээр.

Нөгөө талаар би огт танихгүй гаднын нөхрийг захирлаар хэзээ ч тавьдаггүй. Аль болох дотроосоо тухайн ажилтныг сонгон шалгаруулах замаар албан тушаал ахиулахыг хичээдэг. Энэ нь эрсдэлийг бууруулдаг талтай. Тухайн ажилтны давуу талыг хараад тохирох албан тушаалд нь томилох нь гаднаас хүн авчирснаас илүү үр дүнтэй байдаг. Мөн сайн ажилтан болгоныг дарга болгоод байж бас болохгүй.

-Танайх нийт хэдэн ажилтантай вэ?

-Одоогоор 330 ажилтантай байна. Хүний тоо чухал биш. Ер нь хүмүүсээс ямар компанийг сайн компани гэдэг вэ гэж асуухад баян эсвэл том оффистэй, олон ажилтантай гээд олон янзаар л хариулдаг байх. Харин олон улсад бол хариуцаж авсан ажлаа сайн хийдэг компанийг л сайн гэж үнэлдэг юм билээ. Манайд 10, 20 салбартай том компани гэсэн хэрнээ ажлаа сайн хийдэггүй удирдлага, аж ахуйн нэгжүүд байж л байдаг. Энэ бол буруу стандарт.

-Олонх захирал мэдлэг чадваргүй ажилтнаа шууд л халдаг. Таны хувьд.

-Энэ асуудал их ярвигтай. Шууд халах нь зөв шийдвэр биш л дээ. Манай нөхцөлд мэдлэггүй, чадваргүй гээд нэг ажилтнаа халаад өөр нэгнийг авлаа гэхэд бас л нэг муу хүн ороод ирэх магадлал өндөр шүү дээ. Эцэс төгсгөлгүй халаад байж болохгүй. Тиймээс анх ажилд авахдаа л хүнээ таних хэрэгтэй. Угаасаа засрахгүй залхуу, хүлээсэн үүргээ биелүүлдэггүй, хүнээс үг сонсож чадахгүй байгаа ажилтнаас татгалзахаас өөр аргагүй. Ажил хийдэг газар ажил хийх дургүй, халширдаг хүн хэрэггүй шүү дээ. Ажил хийхгүй хүнийг ажил хий гээд шахаад бас хэрэггүй юм.

-BSB-гийн соёл, үнэт зүйл юу вэ?

-Мэдээж хүн бол манай компанийн хамгийн үнэт зүйл. Гэхдээ үнэ цэнэтэй ажилтан байхын тулд үүрэгт ажлаа шахаж шаардуулаад байлгүй цаг тухайд нь чанартай хийдэг байх хэрэгтэй. Хувийн идэвх зүтгэл, санаачилгатай байх нь зүйн хэрэг. Ер нь Европ хүмүүс маш их бие даасан, хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлчихдэг. Илүү дутуу зүйлд цалгардаад байдаггүй. Харин манайхан даргаараа шаардуулж, шаардуулж хагас дутуу зүйл хийдэг. Зарим дарга нар нь ч буруу шаардлага тавина. Тэгэхээр ямар ажилтанг үнэ цэнэтэй гэж хэлэх вэ гэвэл хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь сайн гүйцэтгэдэг байх ёстой. Өнөөдөр монголчууд ядуу байна гээд байдаг. Ажил хийдэггүй мөртлөө машин унаад давхина. Юу ч хийхгүй байж өдий зэрэгтэй яваад байдаг их азтай ард түмэн. Өөр улс оронд ажил хийхгүй л бол өлсөж үхнэ.

-Сүүлийн үед монгол сэтгэхүйн талаар их ярих боллоо. Монгол сэтгэхүйг хөгжүүлж байж л Монгол Улс хөгжинө гэх бодлоготой Та санал нийлэх үү?

-Тийм шүү сэтгэхүйг өөрчлөх хэрэгтэй. Сэтгэхгүй ямар байна амьдрал тийм л байна. Тэгвэл сэтгэхүйг ахуй төлөвшүүлдэг. Манай ахуй бол маш амирлангуй, өрөвдсөн, тэтгэсэн хандлагатай байдаг. Тиймээс ахуй шударга байх хэрэгтэй. Бэлэн мөнгө тараагаад л. Оюутнуудад гэхэд л архи уух мөнгийг нь бэлнээр өгч байна. Хөдөлмөрлөхгүй хүнд мөнгө өгөх нь шударга зүйл мөн үү. Бид капитализмыг алгасчихсан. Гэтэл яг үнэндээ капитализм чинь хүнийг хөдөлмөрлүүлж сургаж хүмүүжүүлж чаддаг. Тэнд хөдөлмөрлөхгүй л бол мөнгө байхгүй. Тиймээс хар багаасаа биеэ даадаг. Эцэг, эх нь ч үүргийг нь бүрэн дүүрэн ухамсарлуулж өсгөдөг. Гаднын оюутнууд бүгд л цагийн ажил гололгүй хийж, өдрийн хоолоо олж иддэг. Харин манайхан эцэг, эхийнхээ мөнгөөр авсан Ipad-аар тоглоод л гэртээ сууж байна. Энэ нь нэг талаар хүүхдийн буруу биш. Ямар ч хүн бэлэн сайхан зүйл байхад машин угааж хэдэн төгрөг олохыг хүсэхгүй. Харин ч хааяа нэг эрхэлчихээд, “Би таны ганц охин, хүү биз дээ” гэж сануулчихаад хэвтэж байна. Зарим нь эцэг эхээ яаж хөөрхөн аашилж байгаад хүссэнээ авахуулах вэ гэдэгт л толгойгоо гашилгадаг. Энэ бол буруу сэтгэхүй юм. Үүнийг өөрчлөх цаг болсон.

-Нийгмийн сэтгэхүйг өөрчлөхөд төрийн оролцоо хэр чухал гэж Та бодож байна вэ?

-Дээр байгаа хэдэн нөхөд дараа сонгогдохоо бодоод нийгмийн сэтгэхүйгээр тоглож л болохгүй. Мөнгө тараах ч юм уу. Өнөөдөр луйваргүй сонгууль байдаггүй л гэдэг. Луйвардаж гарч ирсэн улстөрчөөс нэг их зарчимч зүйл шаардаад хэрэггүй. Угаасаа л зөв аргаар гарч ирээгүй хүнийг хэзээ зөв болохыг хүлээгээд нэмэргүй гэсэн үг юм. Тиймээс өнөөдрийн энэ байдалд нэг их засаг, төрд найдаад байх хэрэггүй. Бөөн булхай.

-Тэгвэл хэнд найдах вэ?

-Чи өөртөө, би өөртөө л найдах хэрэгтэй.Баруун Европ ингэж л хөгжсөн. Бүгд л өөрөө өөртөө эзэн. Гэтэл манайхан миний ядуу байгаа нь төр, засгийн буруу гэдэг. Тэгсэн нөгөө төр нь тиймээ миний буруу гээд сонин юм яриад байх юм. Тэр чинь тухайн хүний л буруу шүү дээ.

-Манай компаниудын захирлуудын хүүхдүүд тансаг нөхцөлд, тусгай орчинд өсөж, хүмүүжиж, сурч боловсордгийг иргэд мэднэ. Харин бусад оронд бизнесмэнүүд хүүхдүүдээ чанга гараар хүмүүжүүлж, мөнгөний үнэ цэнийг биеэр нь мэдрүүлж өсгөдөг тухай олон ном зохиолоос уншсан юм байна. Харин Та хүүхдүүдээ хэрхэн өсгөж байна вэ?

-Аль болох мөнгөөр эрхлүүлэхгүйг хичээдэг. Олны дунд байлгахыг эрмэлздэг. Ер нь хүүхдийг олон нийтийн дунд байлгавал төлөвших нь хурдан байдаг байх. Тэр утгаараа манай хүүхдүүд улсын жирийн сургуульд л сурдаг. Гэхдээ улсын

ҮЙЛДВЭРЛЭЛ

ШИНЭ ТЕХНОЛОГИ ШИНЭ БОЛОМЖ

Б.УУГАНБАЯР

...Барилгын салбарт сүүлийн үед нэвтрүүлж буй дэвшилт технологи болох бүрэн цутгамал төмөр бетон хийц буюу хэв хашмалыг 100 хувь импортоор авдаг байсныг халж, дотооддоо үйлдвэрлэдэг болов...

“Mongolian Economy” сэтгүүл “Үйлдвэрлэл” гэсэн шинэ булан нээлээ. Энэ буландаа Монголын эдийн засагт үр ашгаа өгөх, импортыг орлох бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй дотоодын компаниудыг танилцуулах юм. Энэ удаад барилгын хэв хашмал үйлдвэрлэж буй TACO компанийн үйлдвэрлэлийг сурвалжиллаа.

Барилгын хана цутгахад ашигладаг хэв хашмалыг манайх Хятад болон БНСУ-аас 100 хувь импортолдог байсан бол хагас жилийн өмнөөс энэ зах зээлд дотоодын үйлдвэрлэгч бий болжээ. TACO компани өнгөрсөн оны есдүгээр сараас евро стандартын хэв хашмалын үйлдвэрийг Монголдоо нээгээд буй юм.

Цаг хугацаа, мөнгөө хэмнэе

Т.Отгонбаяр TACO компанийнхаа нэрийг өөрийн болон гурван хүүхэд эхнэрийнхээ нэрний /Тэмүүжин, Тэмүгэ, Амина, Сараа, Отгонбаяр/ эхний үсгээр товчилж нэрлэжээ. Тэрбээр үйлдвэр нээх санаагаа барилгын чиглэлээр ажилладаг найзынхаа үйлдвэртэй танилцаж

сургууль дотроо бас шилж сонголгүй яах вэ. Ямартай ч хүүхдүүдээ бусдаас тусгаарлахыг хүсдэггүй. Үнэтэй зүйл хэрэглүүлэх нь нэг талаар нийгмээс тусгаарлаж байгаа хэрэг гэж би хувьдаа боддог. Хамгийн гол нь дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц мэдлэг боловсролтой болгохыг зорьдог. Монголын нөхцөлд англи хэлийг зайлшгүй сурах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, сурах нөхцөл бололцоогоор хангаж өгөхийг хичээдэг.

-Та компанийнхаа ирээдүйг хэрхэн төсөөлж байна вэ?

